# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА

2023 оны 06 дугаар сарын 28-ны өдөр

## Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго

Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго нь Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлаар туссан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн явцад 2023 оны эхний хагас жилийн байдлаар хяналт-шинжилгээ хийж, гүйцэтгэлийн хүрсэн түвшинг зорилтот түвшинтэй нь харьцуулан үр дүнг үнэлэх, төлөвлөлт, биелэлт болон хэрэгжүүлсэн үйл ажиллагаа нь үр дүнтэй байсан эсэхэд чанарын үнэлгээ хийх, дүгнэлт, зөвлөмж гаргах, төлөвлөсөн зорилт, арга хэмжээг бүрэн биелүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино

## Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд туссан зорилт, арга хэмжээг хяналтад авч, яамны нэгжүүдийн 2023 оны эхний хагас жилийн байдлаар ирүүлсэн хэрэгжилтийн тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийв.

Хяналт-шинжилгээ, үнэлгээг хийхдээ Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг удирдлага болгов.

## Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн

Засгийн газрын 2020 оны 203 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлаар тусгагдсан 16 зорилтын 62 арга хэмжээний хэрэгжилтийг хангаан ажиллаж байна.

Хяналтад авсан 62 арга хэмжээний 42 арга хэмжээг тус яам толгойлон, 20 арга хэмжээг хамтран хэрэгжүүлэхээр тусгагдсан ба хэрэгжилтийг 66.6 хувийн биелэлттэй гэж дүгнэв. Үүнд

Арга хэмжээнүүдийн биелэлтийг бодлогын зорилтоор нь авч үзвэл:

- Ковид-19 халдварт цар тахлаас үүдэлтэй нийгэм эдийн засгийн хүндрэлийг даван туулах бодлогын хүрээний 1 зорилтын 1 арга хэмжээний биелэлт 100.0 хувь,
- Эдийн засгийн бодлогын хүрээний 11 зорилтын 57 арга хэмжээний биелэлт 63.8 хувь,
- Засаглалын бодлогын хүрээний 2 зорилтын 2 арга хэмжээний биелэлт 100.0 хувь,
- Ногоон хөгжлийн бодлогын 2 зорилтын 2 арга хэмжээний биелэлт 95.0 хувь, хэрэгжүүлсэн нийт 62 арга хэмжээний биелэлтийг 66.6 хувьтай дүгнэлээ.

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд туссан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн үнэлгээний товчоо

| Зорилго | Зорилтын тоо | Арга хэмжээний тоо | Хэрэгжилтийн хувь, арга хэмжээний тоо | | | | | | Хэрэгжилт /хувь/ |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 100 | 90 | 70 | 50 | 30 | 0 | |
| Нэг. Ковид-19 халдварт цар тахлаас үүдэлтэй нийгэм эдийн засгийн хүндрэлийг даван туулах бодлого | 1 | 1 | 1 | - | - | - | - | - | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Хоёр. Эдийн засгийн бодлого | 11 | 57 | 7 | 12 | 16 | 10 | 8 | 4 | 63.8 |
| Дөрөв. Засаглалын бодлого | 2 | 2 | 2 | - | - | - | - | - | 100 |
| Тав. Ногоон хөгжлийн бодлого | 2 | 2 | 1 | 1 | - | - | - | - | 95.0 |
| **Дүн** | **16** | **62** | **11** | **13** | **16** | **10** | **8** | **4** | **66.6** |

**Дөрөв. Дүгнэлт**.

Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээний гүйцэтгэл 2023 оны эхний хагас жилийн байдлаар 66.6 хувьтай дүгнэгдсэн бөгөөд 11 арга хэмжээ зорилтот түвшиндээ бүрэн хүрч 100 хувийн гүйцэтгэлтэй, 13 арга хэмжээ гол үр дүн гарч эхэлж байгаа буюу 90 хувь, 16 арга хэмжээ гүйцэтгэл нь тодорхой хэмжээгээр гарч эхэлж байгаа буюу 70 хувь, 10 арга хэмжээ ажил тодорхой хэмжээнд эхэлсэн буюу 50 хувь, 8 арга хэмжээ боловсруулалтын шатанд буюу 30 хувь, үр дүнгүй 4 арга хэмжээ байна.

**Тав. Санал, зөвлөмж.**

1. Засгийн газрын 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн хуралдааны “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2022 оны хэрэгжилтийн тухай” 05 дугаар тэмдэглэлд Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд туссан хэрэгжилт удаашралтай байгаа арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлж, тухайн жилд хүргэхээр тооцсон зорилтот түвшинд хүргэх арга хэмжээг зохион байгуулж ажиллахыг үүрэг болгосныг хэрэгжүүлж ажиллах,
2. Салбарын урт болон дунд хугацааны бодлогын баримт бичгүүдтэй уялдуулан, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинг үндэслэн биелэлтийг тайлагнаж хэвших,
3. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2022 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн “Хэрэгжилтийг хангах, үр дүнг сайжруулах тухай” 03 дугаартай албан даалгаварын хэрэгжилтийг хангаж ажиллах;
4. Төрийн захиргааны удирдлагын газраас хэрэгжилтийн тайланг дотоод нэгжүүд болон харьяа байгууллагуудаас гаргуулж нэгтгэн боловсруулахдаа тухайн зүйл, заалтаар өгөгдсөн үүрэгт хамаарах хэрэгжилтийг оновчтой, тодорхой гаргуулах, холбогдох тушаал, шийдвэр болон албан бичгийн огноо, дугаарыг тодорхой бичих, тайлангийн чанар, утга найруулгыг хянах.

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР

ЗАСГИЙН ГАЗРЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНД УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ ЭРХЛЭХ АСУУДЛААР ТУСГАГДСАН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ
(2023 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн байдлаар)

| № | Зорилт | Арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага | Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг) | 2023 оны зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Хүрсэн түвшин, үр дүн | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
| НЭГ. КОВИД-19 ХАЛДВАРТ ЦАР ТАХЛААС ҮҮДЭЛТЭЙ НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ХҮНДРЭЛИЙГ ДАВАН ТУУЛАХ БОДЛОГО | | | | | | | | |
| 1 | 1.1.6. Нүүрс, бусад уул, уурхайн бүтээгдэхүүний экспортыг эрчимжүүлэх хүрээнд "Ногоон гарц" түр журмыг хэрэгжүүлнэ. Худалдааны түнш орнуудтай эдийн засгийн хамтын ажиллагааг идэвхжүүлж экспортыг нэмэгдүүлнэ. | 1. Нүүрс, уул, уурхайн бусад бүтээгдэхүүний экспортыг эрчимжүүлэх хүрээнд "Ногоон гарц" түр журмыг хэрэгжүүлнэ. Худалдааны түнш орнуудтай эдийн засгийн хамтын ажиллагааг идэвхжүүлж экспортыг нэмэгдүүлнэ. | 2021 - 2024 | ГХЯ, ЗТХЯ, УУХҮЯ, ЭТТ | - | Худалдааны түнш орнуудтай эдийн засгийн хамтын ажиллагааг идэвхжүүлж экспортыг нэмэгдүүлнэ. | Нүүрс, уул уурхайн бусад бүтээгдэхүүний экспортыг эрчимжүүлэх хүрээнд Ногоон гарц түр журам бүрэн хэрэгжсэн. 2023.06.01-ний өдрийн байдлаар 24,0049.1 мян.тн нүүрс, 630.2 мян.тн зэсийн баяжмал, 2,232.6 мян.тн төмрийн хүдэр, баяжмал, 82.7 мян.тн цайрын баяжмал, 304.9 мян.тн хайлуур жоншны баяжмал экспортолсон. Алт олборлолт 5.67 тн байна. 2023 оны II улиралд нүүрс 65.9%, зэсийн баяжмал 45.1%, төмрийн хүдэр, баяжмал 26.5%, цайрын баяжмал 83.6%, хайлуур жоншны баяжмал 84.1%-ийн экспортын, алт олборлолт 25.6%-ийн гүйцэтгэлтэй байна. | 100 |
| ГУРАВ. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО | | | | | | | | |
| 2 | 3.2.1. Стратегийн ач холбогдол бүхий ордуудын эдийн засгийн үр өгөөжийг дээшлүүлнэ: | 1. Оюутолгойн төслийг Монгол Улсын хууль тогтоомжид нийцүүлж, далд уурхайг ашиглалтад оруулна. | 2021 - 2024 | “Оюу Толгой” ХХК | 2023 онд далд уурхайн бүтээн байгуулалтын ажилд төсөв тусгаагүй. | Далд уурхайн бүтээн байгуулалт 89 хувь. | Далд уурхайн бүтээн байгуулалтад 2023.02.01-ний өдрийн байдлаар 5,504 сая ам.долларыг зарцуулсан. 2023 онд нийт 804 сая ам.доллар зарцуулахаар төлөвлөсөн бөгөөд үүнээс 1 дүгээр сард нийт 58 сая ам.долларыг зарцуулсан. Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд 2023 онд далд уурхайн бүтээн байгуулалтыг 89 хувьд хүргэнэ гэж тусгасан. 2023 оны I улирлын байдлаар Оюу толгойн | 90 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | далд уурхайн төслийн бүтээн байгуулалтын ажлын гүйцэтгэл 86%, налуу амны барилгын ажлын гүйцэтгэл 35%, агааржуулалтын урд амны (шафт 3) босоо нэвтрэлт 413 метрт, агааржуулалтын хойд амны (шафт 4) босоо нэвтрэлт 541 метрт тус тус хүрээд байна. Далд уурхайн хүдэр олборлолтын ажлыг 3 дугаар сарын 13-нд эхлүүлсэн. Цаашдаа шат дараатайгаар налуу амны конвейерын газар доорх болон газар дээрх дэд бүтцийн барилгын ажил, агааржуулалтын босоо амнуудын нэвтрэлт, угсралт, баяжуулах үйлдвэрийн өргөтгөлийн ажлуудыг хэрэгжүүлснээр үйлдвэрлэлийн хүчин чадал 2025 оны I улиралд хоногт 30 мян.тн хүртэл, 2027 оны II улиралд хоногт 45 мян.тн хүртэл, 2030 оны III улиралд хоногт 95 мян.тн хүртэл хүдэр олборлохоор төлөвлөж байна. Ингэснээр жилд 40.0 сая.тн хүдэр олборлож, 1,553.0 мян.тн зэсийн баяжмал үйлдвэрлэнэ. Зэсийн баяжмал дахь зэс 436.0 мян.тн, алт 502.0 мян.унц, мөнгө 3495.0 мян.унцад хүрч, экспортын орлого 26.62%-иар нэмэгдэнэ. | |
| 3 | | 2. "Эрдэнэт үйлдвэр" төрийн өмчит үйлдвэрийн газрын өмчлөлтэй холбоотой асуудлыг эцэслэн шийдвэрлэж, ил уурхай, баяжуулах үйлдвэр, засвар механикийн заводод өргөтгөл, шинэчлэлийг хийж, үйлдвэрлэлийн хүчин чадал, өгөөжийг нэмэгдүүлнэ. | 2020 - 2024 | "Эрдэнэт Үйлдвэр" ТӨҮГ, ТӨБЗГ | 397,201.0 сая.төг Гадаад, дотоодын хөрөнгө оруулалт /Өөрийн хөрөнгөөр 13.1 %-ийг, зээлээр 86.9%-ийг (“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ) | Баяжуулах үйлдвэрийн өргөтгөл, шинэчлэл 98 хувьд, засварын механикийн заводын өргөтгөл, шинэчлэлийг 100 хувьд хүргэнэ. | Хүдрийн ил уурхайд мөчлөгт урсгалт тээврийн технологи нэвтрүүлэлт 45%, эмульсийн тэсрэх бодисын үйлдвэрийн бүтээн байгуулалт 90%, баяжуулах үйлдвэрийн өргөтгөл, шинэчлэл 100%-д тус тус хүрсэн. Засварын механикийн заводын ТЭЗҮ-ийг ЭБМЗ-өөр хэлэлцүүлж хүлээн авсан. Ажлын гүйцэтгэл 9%-тай байна. "Эрдэнэт Үйлдвэр" ТӨҮГ-ын ил уурхай, баяжуулах үйлдвэр, засвар механикийн заводод өргөтгөл, шинэчлэлийг хийж, үйлдвэрлэлийн хүчин чадал, өгөөжийг нэмэгдүүлэх ажлын гүйцэтгэл 83%-тай байна. | 90 |
| 4 | | 2.3. Баяжуулах үйлдвэрийн өргөтгөл, шинэчлэл | 2020 - 2023 | "Эрдэнэт Үйлдвэр" ТӨҮГ, туслан гүйцэтгэгч | 358,220,8 сая.төг Гадаад, дотоодын хөрөнгө | Баяжуулах үйлдвэрийн өргөтгөл, шинэчлэл 98 хувьд хүрнэ. | Баяжуулах үйлдвэрийн хүдэр боловсруулах хүчин чадлыг шат дараатай нэмэгдүүлэх өргөтгөл шинэчлэлийн ажлын хүрээнд Өөрөө нунтаглах хэсэгт жилийн 6.0 сая.тн хүдэр боловсруулах хүчин чадалтай өргөтгөлийн 4 дүгээр шугамыг байгуулах ажлыг 2019- | 90 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | "Jiangxi Naipu mining machinery and new materials" Co.ltd, "FLSmidth Mongolia" ХХК | оруулалт /Өөрийн хөрөнгөөр 36%-ийг, зээлээр 64%-ийг ("Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ) | | 2022 онд хийж, ашиглалтад оруулаад байна. Уг шугам нь 2015 онд ашиглалтад орсон 3 дугаар шугамтай тоног төхөөрөмж, технологийн хувьд адилхан юм. 2022 оны 08 дугаар сард эхний 2 төслийн ажлыг бүрэн дуусгаж ашиглалтад оруулсан. 3 ажил (Хүдэр бутлах, нунтаглах хэсгийн өргөтгөл, шинэчлэл, Өөрөө нунтаглах хэсгийн хүчин чадлыг 2 сая тн/жилээр нэмэгдүүлэх, Хаягдал өтгөрүүлэх технологийг судалж, нэвтрүүлэх) тендер зарлагдаж, гүйцэтгэгчийг шалгаруулан гэрээ байгуулсан. Дээрх Баяжуулах үйлдвэрийн өргөтгөл, шинэчлэлийн ажлыг график, төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлж байна. Өөрөө нунтаглах хэсгийн хүчин чадлыг 2 сая тн/жилээр нэмэгдүүлэх ажлын зураг төсөл хийгдсэн. Гэрээг 2023 оны 01 дүгээр сард байгуулсан, гэрээний үнийн дүн 30,324,526 ам.доллар. Гэрээний 10% урьдчилгаа, явцын 1 дүгээр санхүүжилтийн 20%, нийтдээ гэрээний үнийн дүнгийн 30%-ийн (9.097 сая.ам.доллар) төлбөрийг гүйцэтгэгч талд шилжүүлээд байна. Ажлын явц: үндсэн тоног төхөөрөмж болон цахилгаан хөдөлгүүр, давтамжийн хувиргагчийн үйлдвэрлэл эхэлсэн. Үндсэн тоног төхөөрөмж болох тээрэм түүний иж бүрдлүүдийн үйлдвэрлэл 2023 оны 12 дугаар сард дуусаж, ачигдана. Цахилгаан хөдөлгүүр 2024 оны 3 дугаар сард, давтамжийн хувиргагч 2024 оны 4 дүгээр сард үйлдвэрлэл дуусаж ачигдахаар төлөвлөж байна. Хүдэр бутлах, нунтаглах хэсгийн өргөтгөл, шинэчлэлийн ажлын ТЭЗҮ, нарийвчилсан зураг төсөл, инженер геологийн судалгаа, байгаль орчны нарийвчилсан үнэлгээ хийх ажилд 13.83 тэрбум төгрөг төсөвлөсөн, ажил хийгдэж байна. Урьдчилгаа төлбөр 20% хийгдсэн. Тус ажил 2023 онд дууснa. Биелэлт-40%. Хаягдлын өтгөрүүлэх технологи нэвтрүүлэх ажлын нарийвчилсан зураг төсөл, инженер геологийн судалгаа, байгаль орчны нарийвчилсан үнэлгээний ажилд 9.808 тэрбум төгрөг төсөвлөсөн, ажил хийгдэж байна. Урьдчилгаа төлбөр (20%) хараахан хийгдээгүй байгаа. Тус ажил 2023 онд дууснa. | |
| 5 | | 2.4. Засварын механикийн заводын өргөтгөл, шинэчлэл | 2020 - 2024 | "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ | 38,980.3 Гадаад, дотоодын хөрөнгө оруулалт | Засварын механикийн заводын өргөтгөл, шинэчлэл 100 хувьд хүрнэ. | УИХ-ын 2020.08.24-ний өдрийн 24 дүгээр тогтоолоор баталсан "Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 3.2.1.2 дахь заалт, "Эрдэнэт үйлдвэрийг 2031 он хүртэл хугацаанд хөгжүүлэх үндсэн чиглэл" мөн Төвийн болон Баруун бүсийн уул уурхай, аж үйлдвэрийн бусад салбарын | 50 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | /Өөрийн хөрөнгөөр 22%-ийг, зээлээр 78%-ийг (“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ) | | импорт орлох металл бүтээгдэхүүний зарим хэрэгцээг хангах зорилтын хүрээнд цутгамал бүтээгдэхүүн, механик боловсруулалттай эд анги, барилгын болон үйлдвэрийн зориулалттай ган хийц, стандартын бус тоног төхөөрөмж, резинэн эдлэл, элэгдсэн эд ангийг сэргээн засварлах үйлдвэрлэлд түшиглэсэн уул уурхай, хүнд үйлдвэр, хөдөө аж ахуйн машин механизм, тоног төхөөрөмжийн сэлбэг хэрэгслийн үйлдвэрлэлийг хөгжүүлж байна. Засвар, механикийн заводыг (2020-2024 он) үндэсний машин үйлдвэрийн суурь болгон хөгжүүлэх өргөтгөл, шинэчлэлийн нарийвчилсан ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах төслийн ажлыг 2021.08.24-ний өдрийн 5/196-21 тоот гэрээний дагуу Засвар, механикийн заводыг үндэсний машин үйлдвэрийн суурь болгон хөгжүүлэх өргөтгөл шинэчлэлийн нарийвчилсан ТЭЗҮ боловсруулах” төслийн ажлыг Ди Ди Эй Жи ХХК боловсруулж дуусгаж, 2022.08.18-нд УУХҮЯ-ны ЭБМЗ-ийн Боловсруулах үйлдвэрийн салбар зөвлөлөөр хэлэлцүүлэн дэмжигдэж, тус зөвлөлийн 2022.09.13-ны өдрийн СТР-2022-02 дугаартай дүгнэлт гарсан. Төслийн ажлын хүрээнд Цутгуурын үйлдвэрлэлийн Илчийн боловсруулалтын тасгийн өргөтгөлийн ажил эхэлж 2023 оны гүйцэтгэх графикт ажлын 45% орчим, нийт ажлын 15.5%-ийн гүйцэтгэлтэй байна. Механик цехийн өргөтгөл шинэчлэлийн зураг төсөл боловсруулах төслийн ажил 100% гүйцэтгэсэн. 2023 оны 06 дугаар сарын байдлаар тендер зарлаж, сонгон шалгаруулалтын ажил явагдаж байна. ЗМЗ-ын өргөтгөл шинэчлэлийн ажлын нийт хөрөнгө оруулалт 148.67 сая.ам.доллар, үүнээс 8.47 сая.ам.доллар санхүүжилт хийгдсэн, үлдэгдэл санхүүжилт 140.20 сая.ам.доллар байна. | |
| 6 | | 3. Цагаан суваргын зэс, молибденийн ордыг ашиглалтад оруулна. | 2021 - 2024 | "Эрдэнэ цагаан суварга" ХХК | 250,384.6 сая төгрөг | Бүтээн байгуулалтын ажил 100 хувьтай. Уулын баяжуулах үйлдвэр төслийн хүчин чадлаар ажиллана. | Цагаан суваргын зэс, молибдений ордыг ашиглах ТЭЗҮ-ийн тодотголыг боловсруулж 2021 онд ЭБМЗ-ийн хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлсэн. Төсөл боловсруулагч хөрөнгө оруулалтыг шийдвэрлэх зорилгоор уулзалт, хэлэлцээрүүдийг хийж байна. Өнөөдрийн байдлаар бүтээн байгуулалтын ажил 69%-тай байна. Уулын баяжуулах үйлдвэрийн тоног төхөөрөмжийн угсралт, туршилт, тохируулгын ажлыг 2023 онд хийж баяжуулах үйлдвэрийг ашиглалтад оруулахаар төлөвлөн ажиллаж байна. Төслийн талбайд 2022 онд барилга угсралтын ажил хийгдээгүй. Монгол | 30 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 7 | | | | | | | Улсын Ерөнхий сайдын 2022 оны 1 дүгээр албан даалгаварт тусгагдсан Цагаан суваргын зэс, молибдений төслийг эрчимжүүлэх арга хэмжээний талаар танилцуулга бэлтгэн Засгийн газрын 2022.04.20-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж холбогдох шийдвэрийг гаргуулсан. Монгол Улсын Засгийн газрын 2022.04.20-ны өдрийн хуралдааны 24 дүгээр тэмдэглэлийн 1-д Цагаан суваргын зэс, молибдений ордыг эдийн засгийн эргэлтэд оруулах хүрээнд тоног төхөөрөмж суурилуулалт, барилгын бүтээн байгуулалтын ажилд шаардлагатай гадаадаас ажиллах хүч, мэргэжилтнийг авах талаар холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн арга хэмжээ авч ажиллахыг УУХҮСайд болон ХНХСайд нарт даалгасан. Мөн хуралдааны тэмдэглэлд үйлдвэрийн үйл ажиллагаанд шаардлагатай гааль, нэмэгдсэн өртгийн албан татвар төлөлтийн хугацааг хойшлуулах шийдвэр гаргахыг Сангийн сайдад даалгасан. Уг тэмдэглэлийн дагуу холбогдох арга хэмжээг авч ажилласан. УУХҮСайд тус төслийн бүтээн байгуулалттай газар дээр нь очиж танилцсан.<br>Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2023.03.06-ны өдрийн А/55 дугаар тушаалаар Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг шинэчлэн боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг шинэчлэн байгуулсан. Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн Үзэл баримтлалыг 2023.05.02-ны өдөр Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Сангийн сайд Б.Жавхлан, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар нараар батлуулсан.<br>Зэсийн АМНАТ-ийн нэмэлт хувийг эргэн харж, шинэчлэн сайжруулах шаардлагатай бөгөөд Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах ажлын хэсэг шийдвэрлэхээр ажиллаж байна. | |
| 7 | | 4. Багануур, Шивээ-Овоогийн нүүрсний уурхайд өргөтгөл хийж, олборлолтын хүчин чадлыг нэмэгдүүлж өртөг, | 2020 - 2024 | "Эрдэнэс Монгол" ХХК "Багануур" ХК, "Шивээ-Овоо" ХК | | "Багануур" ХК-ийн ил уурхайн хүчин чадал 5.0 сая.тн-д, "Шивээ овоо" ХК-ийн ил уурхайн үндсэн | Багануурын нүүрсний уурхайн үндсэн тоног төхөөрөмжийн шинэчлэлт 50%, Шивээ-Овоогийн нүүрсний уурхайн үндсэн тоног төхөөрөмжийн шинэчлэлт 70%-д хүрсэн. | 90 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | зардлыг бууруулна. | | | | тоног төхөөрөмжийн шинэчлэлт 70 хувьд хүргэнэ. | | |
| 8 | | 4.2. Шивээ-Овоогийн нүүрсний уурхайн өргөтгөлийн үлдэгдэл хөрөнгө оруулалт | 2020 - 2024 | "Эрдэнэс Монгол" ХХК "Шивээ-Овоо" ХК | Урьдчилгаа 3.4 тэрбум төгрөг төлж үлдэгдэл төлбөр 4.5 тэрбум төгрөг | "Шивээ Овоо" ХК-ийн ил уурхайн үндсэн тоног төхөөрөмжийн шинэчлэлт 70 хувьд хүргэнэ. | 25 тонны автокран, токарын машиныг уулын үйлдвэрлэлд ашиглаж эхэлснээр дээрх техникүүдийн шинэчлэлийн түвшин 70 хувийн биелэлттэй байна. Шивээ Овоо ХК JBIC төслийн хүрээнд 14.8 тэрбум төгрөгийн зээлийн гэрээгээр 5 комацу HD465 технологийн автомашин, 2 комацу PC1250 гидро экскаватор нийлүүлэгдэж 5.6 тэрбум төгрөгийг төлж үлдэгдэл төлбөр 6.2 тэрбум төгрөг байна. 2023.03.01-ний өдрийн байдлаар нээлттэй сонгон шалгаруулалтаар Барловорлд Монголиа ХХК-иас 7.9 тэрбум төгрөгийн төсөвт өртгийн гэрээтэй нийлүүлсэн 2 CAT777E технологийн автомашины урьдчилгаа 3.378 тэрбум төгрөг төлж үлдэгдэл төлбөр 4.5 тэрбум төгрөг байна. | 90 |
| 9 | | 5. Асгатын мөнгөний ордыг эдийн засгийн эргэлтэд оруулахад шаардлагатай туршилт, судалгаа хийж, хөрөнгө оруулалтын асуудлыг шийдвэрлэнэ. | 2020 - 2024 | "Эрдэнэс Монгол" ХХК | 57,615.5 | Асгатын мөнгөний ордыг эдийн засгийн эргэлтэд оруулахад шаардлагатай туршилт, судалгаа хийж, хөрөнгө оруулалтын асуудлыг шийдвэрлэх ажил 95 хувь. | Монгол Улсын Их Хурлын 2022.01.21-ний өдрийн “Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай” 01 дүгээр тогтоолын 3-т “Асгатын мөнгөний ордод нарийвчилсан хайгуулын ажил гүйцэтгэх, техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах ажлын хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэхийг “Эрдэнэс Монгол” ХХК-д хариуцуулах”, Засгийн газрын 2022.03.16-ны өдрийн хуралдааны 16 дугаар тэмдэглэлээр “Асгатын мөнгөний ордын техник, эдийн засгийн үндэслэлийг шинэчлэн боловсруулж, эдийн засгийн эргэлтэд оруулахад шаардлагатай хөрөнгө оруулалтын эх үүсвэрийн асуудлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд судлан танилцуулахыг “Эрдэнэс Монгол” ХХК-д тус даалгасан. Засгийн газрын тогтоол, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд хийгдсэн туршилт судалгааны ажил, санхүүжилтийн хувилбарт тооцоолол, хөрөнгө оруулалт татах чиглэлээр хийгдсэн ажил, цаашид ордыг эдийн засгийн эргэлтэд оруулахтай холбоотой хөрөнгө оруулалтыг хэрхэн шийдвэрлэхээр төлөвлөж байгаа талаар нарийвчилсан мэдээлэл, танилцуулгыг 2023.02.01-ний өдрийн дотор бэлтгэн ирүүлэх тухай | 30 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | УУХҮСайдын 2023.01.26-ны өдрийн 01/264 дугаар албан бичгээр хүргүүлсэн. | |
| 10 | | 5.3. Асгатын мөнгөний ордын нэмэлт хайгуулын ажлын хөрөнгө оруулалт | 2021 - 2024 | "Эрдэнэс Монгол" ХХК | 1000.0 /Төрийн өмчит компанийн санхүүжилтээр/ | Нэмэлт хайгуулын ажлын хөрөнгө оруулалтыг 67 хувьд хүргэнэ. | Цар тахалтай холбоотой төсөв танах Засгийн газрын чиглэлийн дагуу төсвийн санхүүжилт цуцлагдсан. | 0 |
| 11 | | 5.4. Асгатын мөнгөний ордын дэд бүтэц, бэлтгэл ажлын хөрөнгө оруулалт. | 2021-2023 | "Эрдэнэс Монгол" ХХК | 56,615.5 | Дэд бүтэц, бэлтгэл ажлын хөрөнгө оруулалт 100 хувь | Асгатын ордыг эдийн засгийн эргэлтэд оруулах үйл ажиллагааг идэвхжүүлэх ажлын хүрээнд хүдэр тээвэрлэх технологийн зам, гүүр, туннелийн шинэ маршрут тодорхойлох нарийвчилсан зураг төслийн ажлын гүйцэтгэгчээр шалгарсан “Эн Би Си Си” ХХК болон ЗТХЯ, УУХҮЯ-ны төлөөлөл оролцсон хурлыг 2023.05.04-ний өдөр зохион байгуулж, нөхцөл байдлын талаар санал солилцож, ажлын даалгаварт өөрчлөлт оруулах саналаа “Эрдэнэс Монгол” ХХК боловсруулж, ЗТХЯ, УУХҮЯ хамтран батлахаар тохиролцов. Хүдэр тээвэрлэх технологийн зам, гүүр, туннелийн шинэ маршрут тодорхойлох нарийвчилсан зураг төслийн ажлын даалгаварт Асгатын мөнгөний ордын Штольн-2, Штольн-3 амруу явах замын нарийвчилсан зураг төслийг нэмж тусгахаар тохиролцов. | 30 |
| 12 | | 6.Тавантолгойн нүүрсний бүлэг ордын дэд бүтцийг бүрдүүлж, үйлдвэрлэл, технологийн парк байгуулах ажлын хүрээнд нүүрс баяжуулах үйлдвэрийг ашиглалтад оруулна. | 2021 - 2024 | "Эрдэнэс-Тавантолгой" ХК | 423,946.7 /Төрийн өмчит компанийн санхүүжилтээр | Тавантолгойн нүүрсний бүлэг ордын дэд бүтцийг бүрдүүлж, үйлдвэрлэл, технологийн парк байгуулах ажлын хүрээнд нүүрс баяжуулах үйлдвэрийг ашиглалтад оруулах ажил 60 хувь | Нүүрс баяжуулах үйлдвэрийн төслийн гүйцэтгэл 37%-тай байна. Нүүрс, хөрс тээврийн техник, тоног төхөөрөмжийн нэвтрүүлэлт 30%-д хүрсэн. Ачилтын нэгдсэн төвийн бүтээн байгуулалтын ажлын гүйцэтгэл 65%-тай байна. Загийн усны хоолой усан хангамжийн төслийн бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлсэн бөгөөд төслийн нийт гүйцэтгэл 89%-д хүрсэн. | 70 |
| 13 | | 6.1. 3.2.1.6.1. Техник, тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалт | 2020 - 2024 | "Эрдэнэс-Тавантолгой" ХК | 2023 оны хагас жилийн байдлаар 61.7 тэрбум төгрөг зарцуулсан. | Нүүрс, хөрс тээврийн техник, тоног төхөөрөмжийн | Уурхайн үйл ажиллагаанд шаардагдах уулын үндсэн болон туслах техник нийлүүлэгчийг сонгон шалгаруулах нийт 14 багц тендерийг зохион байгуулж 10 багцад нь буюу экскаватор, автосамосвал, бульдозер, автогрейдеруудийг нийлүүлэгчээр "Хуа Еэ" түншлэл | 90 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | нэвтрүүлэлт 21 хувь | болон "Майнс Ап" ХХК-иуд шалгарсан. Эдгээрээс автосамосвал болон автогрейдерүүдийг нийлүүлэхээр гэрээ байгуулсан "Хуа Еэ" түншлэл нь техникүүдийг уурхайн талбайд авчирч "ЭТТ" ХК-ийн техникийн үзлэг, шалгалтаар оруулсан боловч шаардлага хангаагүй тул гэрээ цуцалсан. Тус техникүүдийн тендер, худалдан авалтын үйл ажиллагааг дахин зохион байгуулна. Экскаватор болон бульдозеруудыг бараа нийлүүлэх хуваарийн дагуу 2023 онд уурхайд бүрэн хүлээн авна. | |
| 14 | | 6.2. 3.2.1.6.2. Конвейерийн системийн хөрөнгө оруулалт | 2021 - 2024 | "Эрдэнэс-Тавантолгой" ХК | 2023 онд 99.30 тэрбум төгрөг зарцуулахаар төлөвлөсөн. /Төрийн өмчит компанийн санхүүжилтээр/ | Цанхийн баруун уурхайн хөрсний конвейерийн систем нэвтрүүлэлт 43 хувь | Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2022.10.04-ний өдрийн А/249 дүгээр тушаалаар Эрдэнэс Тавантолгой ХК-ийн боловсруулсан Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутагт орших Тавантолгой чулуун нүүрсний бүлэг ордыг ил уурхайн хөрс, нүүрс тээвэрт авто-конвейерийн хосолсон тээвэр бүхий мөчлөг-урсгал технологи нэвтрүүлэх төслийн техник, эдийн засгийн үндэслэлийн төсөлд дүгнэлт гаргах үүрэг бүхий шинжээчдийн хэсгийн бүрэлдэхүүнийг байгуулсан.<br><br>Шинжээчдийн бүрэлдэхүүний нэгдсэн санал, дүгнэлтийг 2023.06.05-ны өдөр төсөл боловсруулагчид хүргүүлсэн бөгөөд холбогдох засварыг хийж гүйцэтгэсний дараа Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэхээр төлөвлөж байна. | 30 |
| 15 | | 6.3. 3.2.1.6.3. Нүүрс баяжуулах үйлдвэр | 2021 - 2023 | "Эрдэнэс-Тавантолгой" ХК | 2023 онд 149.09 тэрбум төгрөг зарцуулахаар төлөвлөсөн. | Нүүрс баяжуулах үйлдвэрийн 1 дүгээр модулын бүтээн байгуулалтын ажил 100 хувь | Нүүрс баяжуулах үйлдвэрийн барилгын зураг төсөв боловсруулах, барилга угсралтын ажил гүйцэтгэгчээр БНХАУ-ын “Норинко Интернэшнл Күүперэшн” компани болон “Дади инженеринг девелопмент групп” компаниудын түншлэл шалгаран 2022.04.14-нд гэрээ байгуулан ажиллаж байна. Төслийн ерөнхий гүйцэтгэгч Монгол дах төлөөний газар 2022.07.25-нд байгуулсан. Бэлтгэл ажлын хүрээнд геодез, инженер геологийн судалгаа, БОННҮ, түр ус, цахилгаан хангамжийн эх үүсвэртэй холбох, бетон зуурмагийн үйлдвэр барих, төслийн талбайг хашаажуулах ажлууд хийгдсэн. Архитектор төлөвлөлтийн даалгавар, Загвар зургийг Өмнөговь аймгийн ГХБХБГазар, аймгийн МХГ, аймгийн ОБГ-аар баталгаажуулсан.<br>Ерөнхий төлөвлөгөө, загвар зургийг холбогдох газруудаар батлуулсан. Технологийн схемийг батлан, тоног төхөөрөмж, төмөр хийцийн бүтээцийн эхний | 50 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | багцуудын захиалгыг хийн, үйлдвэрлэлийг эхлүүлсэн. 2023 оны 4 дүгээр сарын сүүлээс эхлэн төслийн талбайд тоног төхөөрөмжийн эхний багцууд болон үйлдвэрийн метал хийцийн бүтээц тээвэрлэгдэн ирж байна. Төслийн явцыг хурдасгах зорилгоор зураг төслийг хэсэгчлэн боловсруулж байгаа бөгөөд түүхий нүүрсний агуулахын зураг төслийг батлуулж, барилга угсралтын ажлыг эхлүүлсэн. Бусад барилгын зураг төслийг хамтад нь 2023 оны III улиралд багтаан батлуулахаар ажиллаж байна. Төслийн талбайд үндсэн үйлдвэр, түүхий нүүрс, бүтээгдэхүүний агуулах зэрэг үйлдвэрийн 8, ажилчдын хотхоны 5, нийт 13 барилга байгууламжийн барилга угсралтын ажлыг 15 компанийн 514 инженер, техникийн ажилтан, 51 техникээр гүйцэтгэж байна. Төслийн барилга угсралт, суурилуулалтын ажилд гадаадаас авчрахаар төлөвлөсөн 191 ажиллах хүчээс эхний 45 хүн төслийн талбайд ажиллаж байна. Мөн нэмэлтээр гадаадаас 300 ажиллах хүч оруулж ирэх талаар холбогдох төрийн байгууллагаас зөвшөөрөл авахаар ажиллаж байна. Цагаан-Овоо багийн иргэдийн хөрөнгийг нөхөн олговрын зориулалтаар үнэлэх ажлын хүрээнд НБҮ-ийн төслийн нөлөөллийн бүсэд байрлаж буй иргэдийн хөрөнгийг үнэлэх ажил багтсан бөгөөд тус ажлыг гүйцэтгэх "Хөрөнгийн үнэлгээний төв" ХХК-тай 2023.05.19-ний өдөр гэрээ байгуулан ажлыг эхлүүлээд байна. Төслийн санхүүжилтэд нийт 210.2 тэрбум төгрөгийг олгосон бөгөөд төслийн нийт гүйцэтгэл 37%-тай явж байна. | |
| 16 | | 6.5. 3.2.1.6.5. Усан хангамж шийдвэрлэх | 2021 - 2023 | "Эрдэнэс-Тавантолгой" ХК | 113.81 /Төрийн өмчит компанийн санхүүжилтээр/ | Усан хангамжийн хөрөнгө оруулалт 74 хувьд хүргэх | Тавантолгой нүүрсний ордын үйл ажиллагааг эрчимжүүлэх арга хэмжээтэй уялдуулан өмнийн говийн бүтээн байгуулалтад шаардагдах ус хангамжийн найдвартай эх үүсвэрийг хангах ажлын хүрээнд нүүрс баяжуулах үйлдвэрийг усаар хангах “Загийн усны хоолой” газрын доорх усны ордоос шугам, хоолой татах ажлын зураг төслийг боловсруулж, Барилга хөгжлийн төвийн шинжээчдийн магадлалаар баталгаажуулсан. Мөн ус татах шугам хоолойн төслийн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг БОАЖЯ-ны мэргэжлийн зөвлөлөөр баталгаажуулсан. Ордоос ус татах шугам хоолойн барилга угсралтын ажлыг гүйцэтгэх гүйцэтгэгч түншлэлүүдтэй гэрээ байгуулан ажлыг 2022 оны 3 дугаар сараас эхлүүлсэн. | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Одоогоор гүний худгуудын өрөмдлөгийн ажил болон өргөх насосын барилгууд дууссан. Усан сангууд болон шугам хоолойн ажлууд хийгдэж байгаа ба барилга угсралтын ажил хэвийн явагдаж байна. Төслийн нийт гүйцэтгэл 2023.06.05-ны байдлаар 89%-тай явж байна. 2023 оны 1 дүгээр улирлаар 69.7%-ийн гүйцэтгэлийг баталгаажуулсан бөгөөд үлдсэн гүйцэтгэлийг баталгаажуулахаар ажиллаж байна. | |
| 17 | 3.2.2. Томоохон ордуудыг ашиглалтад оруулж, экспортын хэмжээг нэмэгдүүлнэ: | 1. Салхитын мөнгөний ордыг төслийн хүчин чадалд хүргэж ашиглана. | 2021 - 2024 | "Эрдэнэс силвер ресурс" ХХК | | Салхитын мөнгөний ордыг төслийн хүчин чадалд хүргэнэ. | 2023.06.05-ны өдрийн байдлаар 261 мян.тн хүдэр олборлож 93 хувийн гүйцэтгэлтэй байна. 3,406 тн баяжмал борлуулж, 51.4 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн байна. Баяжуулах үйлдвэр 2-ыг улсын комисст хүлээлгэн өгөх хүсэлтээ өгсөн. | 70 |
| 18 | | 2. Зүүн цагаан дэлийн жоншны далд уурхайг ашиглалтад оруулна. | 2021 - 2024 | Монголрос-цветмет ТӨҮГ | 2022 оны хагас жилийн байдлаар 39.5 тэрбум төгрөг зарцуулсан | Зүүн цагаан дэлийн жоншны далд уурхайг ашиглалтад оруулна. 100 хувьд хүргэнэ. | Зүүн цагаан дэлийн далд уурхайн 2 налуу амыг холбож, бэлтгэл ажлыг бүрэн гүйцэтгэн 2022.09.28-ны өдөр Улсын комисст хүлээлгэн өгсөн.<br>Уурхайн доод түвшин 1140 м. Уурхайн дэд бүтэц цахилгаан дамжуулах агаарын шугам барих ажил 85%-тай байна. Ажилчдын амрах 54 хүний кэмпийн эхний барилга байгууламжийн ажил бүрэн баригдаж дууссан. Хоёрдахь кемпийн барилга байгууламж 70% гүйцэтгэлтэй байна. Ингэснээр жоншны хүдэр олборлолтыг 2024 оноос эхлүүлэх ажил төлөвлөгөөт хуваарийн дагуу гүйцэтгэгдэж байна. Мөн уурхайн нэвтрэлтийн ажлын гүйцэтгэл төлөвлөгөөт графикийн дагуу 100% гүйцэтгэлтэй байна. | 100 |
| 19 | 3.2.3. Улсын төсвийн хөрөнгөөр хийгдэх геологи, судалгааны ажлыг эрчимжүүлж, эрдэс баялгийн нөөцийг нэмэгдүүлнэ. | 1. 1:50000-ны масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлын хэмжээг нэмэгдүүлж, нутаг дэвсгэрийн 47%-ийг хамруулна | 2021 - 2024 | УУХҮЯ | Улсын төсөв Батлагдсан: 6,630.2 Гүйцэтгэл: 1,416.6 Санхүүжилт: 1,016.6 | Нутаг дэвсгэрийн 46%-ийг хамруулах, ашигт малтмалын хэтийн төлөвтэй 20 талбай ялгана | 2023 онд 1:50000-ны масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн 25 төслийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Үүнд:<br>1. Үргэлжлэн хэрэгжих төслүүдийн 2023 оны төсөв, төлөвлөгөөг УУХҮСайдын 2023 оны А/21 дүгээр тушаалаар баталж, ажлыг эхлүүлсэн.<br>2. Төслүүдийн 2023 оны хээрийн болон суурин боловсруулалтын ажлын хэмжээ, арга, аргачлалттай танилцан хянаж ЭБМЗ-ийн 2023.02.13-17-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн зөвлөлийн дүгнэлтээр баталгаажуулсан.<br>3. Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэж буй 25 төслийн 2023 оны төсөл, төсвийн тодотголыг ЭБМЗ-өөр хэлэлцүүлэн гаргасан дүгнэлтэд үндэслэн УУХҮСайдын 2023.05.19-ний өдрийн тушаалаар батлуулж, | 90 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | судалгааны ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлж байна. Үүнээс 2023 онд үр дүнгийн суурин боловсруулалтын ажилтай 13 төсөлд ҮГА-тай хамтран тайлангийн шуурхай хяналтыг хийсэн.<br>4. Геологийн 1:50000-ны масштабын зураглал, ерөнхий эрлийн Хулд уул-50, Түдэвтэй уул-50, Дэвийн хонгор уул-50, Асгат уул-50 төслүүдийн үр дүнгийн тайланг ЭБМЗ-ийн салбар зөвлөлийн хуралдаанаар 2023.04.10, 11, 14-ний өдрүүдэд хэлэлцэж хүлээн авсан. Ингэснээр 13150,3 км2 талбай буюу 0,84%, нийтдээ 45%-ийг хамруулсан. | |
| 20 | | 2. 1:25000-ны масштабын нарийвчилсан геологийн зураглалын ажлыг эхлэх, нутаг дэвсгэрийн 0.15 хувийг хамруулна | 2022 - 2024 | | - | Нутаг дэвсгэрийн 0.1%-д судалгааны ажлыг гүйцэтгэнэ. | 1:25000-ны масштабын нарийвчилсан геологийн зураглал гүйцэтгэх, түүнд тавигдах шаадлагын төслийг урьдчилсан байдлаар боловсруулж дуусаад байна. | 30 |
| 21 | | 3. Улсын геологийн 1:200000-ны масштабын иж бүрдэл зургийг нэгтгэж дуусах, нутаг дэвсгэрийн 100 хувь хамруулна | 2021 - 2023 | УУХҮЯ | Улсын төсөв Батлагдсан: 456.3 Гүйцэтгэл: 176.8 Санхүүжилт: 135.3 | L, M /N/ хавтгай буюу нутаг дэвсгэрийн 100%-ийг бүрхэх, үр дүнг хүлээн авна. | 1. Монгол орны нутаг дэвсгэрийн M хавтгайн хэмжээнд Улсын геологийн 1:50000-ны масштабын иж бүрдэл зургийг нэгтгэх ажлын 2023 оны төсөв, төлөвлөгөөг УУХҮСайдын 2023 оны А/21 дүгээр тушаалаар батлуулан ажлыг эхлүүлсэн.<br>2. Төслийн 2023 оны хээрийн болон суурин боловсруулалтын ажлын хэмжээ, арга, аргачлалттай танилцан хянаж ЭБМЗ-ийн 2023.02.14-ний өдрийн хуралдаанаар хэлэлцэн баталгаажуулсан. Зөвлөлийн дүгнэлтийг үндэслэн УУХҮС-ын шийдвэрийн төслийг боловсруулан ажиллаж байна.<br>3. Монгол орны нутаг дэвсгэрийн L хавтгайн хэмжээнд улсын геологийн 1:200000-ны масштабын иж бүрдэл зургийг нэгтгэх төслийн эцсийн суурин боловсруулалтын ажилд ҮГА-тай хамтран шуурхай хяналтыг хийсэн. Монгол орны нутаг дэвсгэрийн L болон M хавтгайн (85,9%) хэмжээнд хээрийн судалгааны ажлыг бүрэн дуусгаж, эцсийн үр дүнгийн тайлан боловсруулалтын ажил хийгдэж байна. | 90 |
| 22 | | 4. Агаарын геофизикийн | 2021 - 2024 | УУХҮЯ | Улсын төсөв Батлагдсан: | Ховд-2020 төслийн үр дүнг | 1. Монгол Улсын баруун, баруун өмнөд хэсгийг хамарсан 104,044.0 кв.км талбайд 1:200000-ны | 90 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 1:200000-ны масштабын соронзон судалгааны ажлыг хэрэгжүүлэх, нутаг дэвсгэрийн 70 хувийг хамруулна | | | 1,788.6 Гүйцэтгэл: 23.5 Санхүүжилт: 23.5 | хүлээн авах, нутаг дэвсгэрийн 66.6%-ийг хамруулах, Хангай-1 төслийг эхлүүлнэ. | масштабтай агаарын геофизикийн цогцолбор судалгааны хээрийн ажлын үр дүнг боловсруулах суурин ажил болон Өмнөговь, Дорноговь аймгийн зарим сумдын нутаг дэвсгэрийг хамарсан 954.68 км.кв талбайд шинээр үнэт, өнгөт металл, ГХЭ-ийн хэтийн төлөвийг тодорхойлох геофизикийн ажлын төсөв, төлөвлөгөөг УУХҮСайдын 2023 оны А/21 дүгээр тушаалаар баталсан.<br>2. Шинээр хэрэгжүүлж эхлэх Хангай-1 төслийн ажлыг шилжүүлэн Ханбогдын дүүрэгт гүйцэтгэхээр геофизикийн судалгааны ажлын геологийн даалгаврыг 2023.03.30-ны өдөр батлан, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг 2023.04.04-нд www.tender.gov сайтаар зарласан.<br>Хураангуй жагсаалтад орсон оролцогчид урилгыг хүргүүлж тендерийг 2023.06.05-нд нээж үнэлгээг хийж байна.<br>3. Ховд-2020 төслийн 2023 оны хээрийн болон суурин боловсруулалтын ажлын хэмжээ, арга, аргачлалтай танилцан хянаж ЭБМЗ-ийн 2023.02.14-ний өдрийн хуралдаанаар хэлэлцсэн дүгнэлтийг үндэслэн УУХҮСайдын тушаалаар баталгаажуулсан.<br>4. Төслийн ажлын суурин боловсруулалтын ажилд ҮГА-тай хамтран тайлангийн шуурхай хяналтыг хийсэн. | |
| 23 | | 6. Бүс нутаг болон хотуудын геоэкологи, гидрогеологи, геотермийн судалгааны ажил хийнэ | 2021 - 2024 | УУХҮЯ | Улсын төсөв Батлагдсан: 540.6 Гүйцэтгэл: 224.7 Санхүүжилт: 177.5 | Дархан хотын судалгааны үр дүнг хүлээн авах, Чойбалсан, Ховд, Даланзадгад хот, Хангайн халуун рашаан геотермийн судалгааг үргэлжлүүлэх, Шаргалжуут геотермийн судалгааг эхэлнэ. | 1. Дархан геоэкологи, Ховд геоэкологи, Гүний хагарал-1 төслүүдийн суурин боловсруулалтын ажлын төсөв, төлөвлөгөөг УУХҮСайдын 2023 оны А/21 дүгээр тушаалаар батлуулан ажлыг эхлүүлсэн.<br>2. Төслүүдийн 2023 оны суурин боловсруулалтын ажлын хэмжээ, арга, аргачлалтай танилцан хянаж, ЭБМЗ-ийн 203.02.13, 14-ний өдрийн хуралдаанаар хэлэлцсэн хурлын дүгнэлтийг үндэслэн УУХҮСайдын шийдвэрээр баталгаажуулсан.<br>3. УИХ-аас геологи-хайгуулын ажилд 2023 онд зарцуулах төсвийг ЗГҮАХХАХТ-нд тусгасан хэмжээнээс багаар баталсан тул шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн Чойбалсан, Даланзадгадын геоэкологи, гидрогеологийн судалгаа болон Шаргалжуутын геотермийн судалгааны ажлыг хэрэгжүүлэх боломжгүй болсон.<br>4. Улаанбаатар болон Эрдэнэт хотын геоэкологи, гидрогеологийн судалгааны ажлын үр дүнгийн тайланг | 70 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | ЭБМЗ-ийн салбар зөвлөлийн 2023.04.10, 11-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн хүлээн авсан. | |
| 24 | | 7. Геологийн өв, тулгуур зүсэлт, онцлог тогтоц, тектоник, минерагенийн болон геохими, геофизик, энергийн түүхий эдийн хэтийн төлөвийн сэдэвчилсэн судалгааны ажил хийнэ | 2021 - 2024 | УУХҮЯ | Улсын төсөв Батлагдсан: 3,357.1 Гүйцэтгэл: 467.4 Санхүүжилт: 329.4 | Тек-2021, ТЗ-2021, ЭТЭ-2022 төслийг үргэлжлүүлэх, геофизикийн трансект ГеофТ-2023 төслийг ажлыг эхлүүлнэ. | 1. Мезо-Кайнозой-2021, БМШАМ-2022, Геологийн орчин-2022 төслийн хээрийн болон суурин боловсруулалтын ажлын төсөв, төлөвлөгөөг УУХҮСайдын 2023 оны А/21 дүгээр тушаалаар баталж ажлыг эхлүүлсэн.<br>2. Төслүүдийн 2023 оны суурин боловсруулалтын ажлын хэмжээ, арга, аргачлалтай танилцан хянаж ЭБМЗ-ийн 2023.02.13, 17-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн баталгаажуулсан. Зөвлөлийн дүгнэлтийг үндэслэн УУХҮСайдын шийдвэрээр төсөл, төсвийн тодотголыг баталсан.<br>3. Өмнөговь, Дорноговь аймгийн зарим сумдын нутаг дэвсгэрийг хамарсан 954.68 км.кв талбайд шинээр үнэт, өнгөт металл, ГХЭ-ийн хэтийн төлөвийг тодорхойлох геохимийн ажлын төсөв, төлөвлөгөөг УУХҮСайдын 2023 оны А/21 дүгээр тушаалаар баталсан.<br>4. Шинээр хэрэгжүүлж эхлэх Ханбогдын дүүрэгт гүйцэтгэх геохимийн судалгааны ажлын геологийн даалгаврыг 2023.03.30-ны өдөр батлан, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг 2023.04.04-ний өдөр зарласан. Хураангуй жагсаалтад хамрагдсан оролцогч нарт урилгыг 2023.05.11-нд хүргүүлсэн ба тендерийг 2023.06.12-нд нээнэ. | 70 |
| 25 | | 8. Гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх, ОХУ, БНХАУ, БНСУ, БНКазУ зэрэг гадаад орнуудтай хамтын ажиллагааны хүрээнд геологийн судалгааны ажил хийнэ | 2021 - 2024 | УУХҮЯ | Улсын төсөв Батлагдсан: 227.9 Гүйцэтгэл: 75.1 Санхүүжилт: 56.3 | ОХУ, БНХАУ, БНСУ, БНКазУ-тай хамтарсан геологийн судалгааны ажлын 5-р үе шатны ажлын үр дүнг хүлээн авах, бусад орнуудтай харилцан үр ашигтай төсөл хэрэгжүүлнэ. | 1. ОХУ, БНХАУ, БНСУ, БНКазУ-тай хамтарсан геологийн судалгааны ажлын 5-р үе шатны ажлын суурин боловсруулалтын ажлын төсөв, төлөвлөгөөг УУХҮСайдын 2023 оны А/21 дүгээр тушаалаар баталж ажлыг эхлүүлсэн.<br>2. Төслийн суурин боловсруулалтын ажлын хэмжээ, арга, аргачлалтай танилцан хянаж ЭБМЗ-ийн 2023.02.14-ний өдрийн хуралдаанаар хэлэлцэн гаргасан дүгнэлтийг үндэслэн УУХҮСайдын тушаалаар баталгаажуулсан.<br>3. Төслийн ажлын үр дүнгийн суурин боловсруулалтын ажилд ҮГА-тай хамтран шуурхай хяналтыг гүйцэтгэсэн. | 90 |
| 26 | 3.2.4. Үндэсний геомэдээллийн нэгдсэн санг хөгжүүлж, | 1. Үндэсний геомэдээллийн нэгдсэн сан төслийг | 2021 - 2024 | УУХҮЯ | Улсын төсөв Батлагдсан: 1,018.9 Гүйцэтгэл: | Үндэсний геомэдээллийн нэгдсэн сан хөтөлбөрийн | 1. Үндэсний геомэдээллийн нэгдсэн санг хөгжүүлж, цахимжуулах ажлын хүрээнд 2022 оноос хэрэгжүүлж эхэлсэн Геологийн баримт-1-2022 төслийн 2023 оны | 70 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | цахим системийг нэвтрүүлж, төрийн үйлчилгээг түргэн шуурхай үзүүлнэ. | магматизм, стратиграф болон бусад геологийн мэдээллээр бүрдүүлэх, баяжуулах, мэдээлэл түгээх үйлчилгээг хялбаршуулна | | | 325.1 Санхүүжилт: 236.7 | төрөлжсөн мэдээллийн сан төслийг үргэлжлүүлэх, ажлын явц 80% | төсөв, төлөвлөгөөг УУХҮСайдын 2023 оны А/21 дүгээр тушаалаар баталж ажлыг эхлүүлсэн.<br>2. Төслийн ажлын хэмжээ, арга, аргачлалтай танилцан хянаж ЭБМЗ-ийн 2023.02.16-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлсэн. Зөвлөлийн дүгнэлтийг үндэслэн УУХҮСайдын шийдвэрээр төсөл, төсвийн тодотголыг баталсан. Төсөл үргэлжлэн хэрэгжиж байна. | |
| 27 | | 2. Геологийн чулуун дээжийн сан болон цахим архивыг бүрдүүлэх, баяжуулах, мэдээлэл түгээх үйлчилгээг хялбаршуулна | 2021 - 2024 | УУХҮЯ | Улсын төсөв Батлагдсан: 1,057.06 Гүйцэтгэл: 393.7 Санхүүжилт: 293.8 | Геологийн чулуун дээжийн сан болон цахим архив бүрдүүлэх төслийг үргэлжүүлэх, ажлын явц 90% | 1. Геологийн судалгааны ажлын үр дүнд цугларсан чулуун дээж болон Геологийн баримтын төв архивт цаасан байдлаар хадгалагдаж байгаа баримтыг цахимжуулах ажлын хүрээнд 2022 оноос хэрэгжүүлж эхэлсэн. Цахим архив-1-2022, Чулуун дээжийн сан-1-2022 төслийн 2023 оны төсөв, төлөвлөгөөг УУХҮСайдын 2023 оны А/21 дүгээр тушаалаар баталж ажлыг эхлүүлсэн.<br>2. Төслүүдийн ажлын хэмжээ, арга, аргачлалтай танилцан хянаж ЭБМЗ-ийн 2023.02.16-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлсэн. Зөвлөлийн дүгнэлтийг үндэслэн УУХҮСайдын шийдвэрээр төсөл, төсвийн тодотголыг баталсан. Төсөл үргэлжлэн хэрэгжиж байна. | 70 |
| 28 | 3.2.5. Өндөр технологийн түүхий эд болох газрын ховор элемент, үнэт, өнгөт, хар, холимог металл, металл бус ашигт малтмал болон газрын тосны эрэл, хайгуулын ажлын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх | 1. Газрын ховор элемент болон өндөр технологийн түүхий эдийн суурь судалгааны ажил хийх, хэтийн төлөвийн үнэлгээ өгнө | 2021 - 2024 | УУХҮЯ | Улсын төсөв Батлагдсан: 2,419.1 Гүйцэтгэл: 158.7 Санхүүжилт: 123.2 | ГХЭ-ийн төслийн үр дүнг хүлээн авах, өндөр технологийн түүхий эдийн судалгааг үргэлжлүүлнэ. | 1. Газрын ховор элемент болон өндөр технологийн түүхий эдийн суурь судалгааны ажил хийх, хэтийн төлөвийн үнэлгээ өгөх зорилгоор хэрэгжүүлж байгаа ӨТТЭ-1-2021, ӨТТЭ-2-2022 төслүүдийн төсөв, төлөвлөгөөг УУХҮСайдын 2023 оны А/21 дүгээр тушаалаар баталж ажлыг эхлүүлсэн.<br>2. Төслүүдийн 2023 оны ажлын хэмжээ, арга, аргачлалтай танилцан хянаж ЭБМЗ-ийн 2023.02.14, 17-ны өдрийн хуралдааанаар хэлэлцэн шийдвэрлүүлсэн дүгнэлтийг үндэслэн УУХҮСайдын шийдвэрээр төсөл, төсвийн тодотголыг баталсан.<br>3. ӨТТЭ-1-2021 төслийн ажлын үр дүнгийн тайлангийн явцад ҮГА-тай хамтран шуурхай хяналтыг хийсэн. | 70 |
| 29 | | 2. Үнэт, өнгөт, хар, ховор, холимог металл болон металл бус ашигт | 2021 - 2024 | УУХҮЯ | Улсын төсөв Батлагдсан: 6,028.6 Гүйцэтгэл: | Өнгөт, хар металлын чиглэлээр эрэл, үнэлгээний ажлыг үргэлжлүүлэх, | 1. Үнэт, өнгөт, хар, ховор, холимог металлын эрэл үнэлгээний ЭҮ-2-2021, ЭҮ-3-2021, ЭҮ-4-2022 болон Монгол орны алтны металлогени /1:500000-ны масштаб/, өмнөд бүсийн алтны хэтийн төлөвийн судалгааны Мета-алт-500 төслийн төсөв, төлөвлөгөөг | 90 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | замаар эрдэс баялгийн нөөцийг арвижуулна. | малтмалын нарийвчилсан, эрэл, үнэлгээний ажил хийх, хэтийн төлөвийн үнэлгээ өгнө | | | 815.9 Санхүүжилт: 612.2 | металл бус ашигт малтмалын судалгааг эхлэх, хэтийн төлөвийн үнэлгээ өгнө. | УУХҮСайдын 2023 оны А/21 дүгээр тушаалаар баталж ажлыг эхлүүлсэн.<br>2. Төслүүдийн 2023 оны ажлын хэмжээ, арга, аргачлалтай танилцан хянаж ЭБМЗ-ийн 2023.02.14, 17-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлсэн. Зөвлөлийн дүгнэлтийг үндэслэн УУХҮСайдын шийдвэрийн төслийг боловсруулж байна.<br>3. ЭҮ-1-2020 төслийн үр дүнгийн тайланг ЭБМЗ-ийн салбар зөвлөлийн 2023.04.12-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн хүлээн авсан.<br>4. Монгол орны баруун, баруун өмнөд бүсийн алтны хэтийн төлөвийг тогтоох БӨМ-Алт-2019 төслийн үр дүнгийн тайланг ЭБМЗ-ийн салбар зөвлөлийн 2023.04.11-ний өдрийн хуралдаанаар хэлэлцэн хүлээн авсан. | |
| 30 | | 3. Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олголтыг нэмэгдүүлж, хайгуулын ажлыг эрчимжүүлэн геологийн нөөцийг өсгөнө | 2021 - 2024 | УУХҮЯ, АМГТГ | - | Ашигт малтмалын хайгуулын 60-80 тусгай зөвшөөрөл шинээр олгон, хайгуулын ажлыг эрчимжүүлж геологийн нөөцийг өсгөнө. | - Зөвшөөрлийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан 2023.01.06-ны өдөр Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт орсон. Уг өөрчлөлтийн дагуу УУХҮСайдын 2023 оны А/48 дугаар тушаалаар Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтаар олгох журмыг, А/49 дүгээр тушаалаар Сонгон шалгаруулалтын комиссын бүрэлдэхүүнийг тус тус баталсан. Холбогдох хууль, журамд заасны дагуу www.tender.gov.mn платформоор нийтэд зарлаж байна.<br>- 2023.02.03-ны өдөр зарласан 25 талбайн тендерийн нээлтийг 2023.03.06-ны өдөр хийж үнэлгээг хийсэн ба 8.2 тэрбум төгрөгийн санал ирүүлсэн.<br>- 2023.03.06-ны өдөр зарласан 25 талбайн тендерийн нээлтийг 2023.04.06-ны өдөр хийж үнэлгээг хийсэн ба 2 тэрбум төгрөгийн санал ирүүлсэн.<br>- 2023.03.24-ний өдөр 25 талбайд зарласан сонгон шалгаруулалтыг 2023.04.26-нд нээж үнэлгээг хийсэн ба 2 тэрбум төгрөгийн санал ирүүлсэн.<br>- 2023.04.07-ны өдөр 25 талбайн хэмжээнд сонгон шалгаруулалт зарласан ба 2023.05.10-нд үнийн саналыг нээсэн бөгөөд 2023.05.21-ний өдөр үр дүнг олон нийтэд мэдээлсэн бөгөөд төлбөрийн зөрүү төлөх хоног явж байна.<br>- 2023.05.03-ны өдөр 25 талбайн хэмжээнд сонгон шалгаруулалт зарласан ба 2023.06.02-нд нээж үнэлгээг хийж байна. | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | - 2023.05.15-ны өдөр 25 талбайн хэмжээнд сонгон шалгаруулалт зарласан ба 2023.06.14-нд нээж үнэлгээг хийхээр хүлээж байна.<br>Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтаар олгох ажлын хүрээнд 2023 оны эхний хагас жилийн байдлаар 681,565.0 га талбайг хамарсан 200 талбайд ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтыг зарлан үнэлгээ хийх үйл ажиллагааг зохион байгуулсан. Үүний үр дүнд 342,348.0 га талбайг хамарсан 98 хайгуулын тусгай зөвшөөрлийг шинээр олгосон. Сонгон шалгаруулалтаар улсын төсөвт 18,6 тэрбум төгрөгийг төвлөрүүлсэн. | |
| 31 | 3.2.6. Уул уурхайн салбарын институцийг бэхжүүлж, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлж, лиценз олголтыг олон нийтэд нээлттэй болгож, хууль зөрчиж олгосон зөвшөөрлийг хүчингүй болгоно. | 2. Уул уурхайн салбарын судалгаа шинжилгээний байгууллагыг нэгдсэн зохион байгуулалтад оруулах асуудлын хүрээнд яамны харьяанд аж ахуйн тооцоот газрыг бий болгоно. | 2020 - 2024 | УУХҮЯ, УУБГ | 2500.0 сая төгрөг | Засгийн газрын шийдвэрийн дагуу уул уурхайн салбарын судалгаа шинжилгээний байгууллагыг байгуулна.100 хувьд хүргэнэ. | Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд Уул уурхайн салбарын судалгаа шинжилгээний байгууллагыг бий болгохоор тусгасан. Уул уурхайн судалгаа, хөгжлийн төв байгуулах талаар Засгийн газрын тогтоолын төсөл болон төрийн өмчит аж ахуйн тооцоот газрын дүрмийн төслийг боловсруулсан бөгөөд холбогдох тооцоо, судалгааг яамны удирдлагад танилцуулсан. Канадын Засгийн газрын дэмжлэгтэйгээр хэрэгжүүлж байгаа Мерит төслийн удирдлагад 2022-2023 оны төлөвлөгөөнд энэ асуудлаар хамтран ажиллах санал хүргүүлсэн. Төрийн хэмнэлтийн тухай хууль батлагдсантай холбогдуулан түр хугацаагаар хойшлуулаад байна. | 30 |
| 32 | | 3. Орон нутагт эрдэс баялгийн асуудал хариуцсан нэгж байгуулна. | 2021 - 2024 | УУХҮЯ, УУБГ | 818.6 сая төгрөг | Засгийн газрын шийдвэрийн дагуу орон нутагт эрдэс баялгийн асуудал хариуцсан нэгж байгуулагдана. 100 хувьд хүргэнэ. | Орон нутагт эрдэс баялгийн нэгж байгуулах ажлын хүрээнд эхний ээлжинд Өмнөговь, Дорноговь, Дорнод, Ховд, Орхон аймгуудад байгуулахаар "Зарим орон нутагт Эрдэс баялгийн нэгж байгуулах тухай" Засгийн газрын тогтоолын төсөл боловсруулсан бөгөөд яамдаас санал авч, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр ЗГХЭГ-т хүргүүлсэн боловч Сангийн яамны саналыг заавал авахаар буцаасан. Сангийн яамнаас “Нэр дурдсан аймгуудад байгуулах Эрдэс баялгийн хэлтсийг тухайн аймгийн Засаг даргын Тамгын газарт бус харин Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ашигт малтмал, газрын тосны газрын харьяанд 2022 оноос эхлэн байгуулахаар тогтоолын төслийг өөрчлөх” гэсэн санал ирүүлсэн. Энэ саналтай уялдуулан Сангийн яам холбогдох орон тоо, төсвийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2022 оны төсөвт | 90 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 1,0 тэрбум төгрөг тусгасан. Дээрх нөхцөл байдалд тохируулан Засгийн газрын тогтоолыг дахин боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр ЗГХЭГ-т 2022.04.11-ний өдөр хүргүүлсэн. Уг асуудлыг 2022.08.03-ны өдрийн Засгийн газрын ээлжит хуралдаанаар хэлэлцүүлж, АМГТГ-ын орон нутаг дахь төлөөлөгчийн газрууд бий болсон ба АМГТГ-ын орон тооны хязгаар 150 байсныг 185 хүнтэй болгосон талаар 295 дугаар тогтоол батлагдсан. АМГТГ уг ажлыг зохион байгуулан ажиллаж байна. | |
| 33 | | 4. Шинэ бүтээн байгуулалтын ажилд зайлшгүй шаардлагатай хүний нөөцийг бэлтгэх, мэргэшүүлэх ажлыг хамтын ажиллагааны хүрээнд холбогдох яам, байгууллагатай зохион байгуулна. | 2021 - 2024 | УУХҮЯ, УУБГ, ГБГ | Төсөв тусгагдаагүй | | Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор баталсан “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг хэрэгжүүлэх эхний үе шатны үйл ажиллагааны хөтөлбөрийн 6.3.5 дахь заалтад хувийн хэвшлийн гадаадаас авах ажиллах хүчний тоонд хязгаарлалт тогтоохгүй байх, хууль тогтоомжийн дагуу ногдуулах ажлын байрны төлбөрийг 50 хувиар хөнгөлөх гэж заасан бөгөөд мөн тогтоолын хавсралтаар Тавантолгой болон бусад нүүрсний ордыг иж бүрнээр нь ашиглах болон бусад төслүүд багтсан. Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1.4 дэх заалтыг үндэслэн “Шинэ сэргэлтийн бодлого батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтын 6.3.5-д заасныг хэрэгжүүлэх зорилгоор “Гадаадаас 2022 онд авах ажиллах хүч, мэргэжилтний хувь хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Засгийн газрын тогтоолын төсөлд санал хүргүүлсэн. Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2.6-д заасны дагуу тус яамнаас нийт давхардсан тоогоор 94 аж ахуйн нэгжийн 3555 инженер, техникийн ажилтны холбогдох материалыг судалж Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам болон Хөдөлмөр, халамжийг үйлчилгээний газарт тодорхойлолт хүргүүлсэн. Уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарт мэргэжилтэн, боловсон хүчин бэлтгэдэг Их, дээд сургуулиудын нэг болох Монгол-Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургууль (МГТИС)-д бэлтгэгддэг Байгалийн нөөц, технологийн магистр /Master in Resources and Technology/-ын хөтөлбөрт тохирох индекс одоогоор байхгүй байгаа тул тохирох хөтөлбөрийн нэр, индексийг жагсаалтад бүртгүүлэх хүсэлтийг БШУЯ-нд хүргүүлсэн. Ажиллах | 70 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдаж, ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хууль 2022.07.01-ний өдрөөс эхлэн хүчингүй болсон. Уг хууль батлагдсантай холбогдуулан “Гадаадаас авах нарийн мэргэжлийн ажлын байрны жагсаалт батлах тухай” Засгийн газрын тогтоолын төсөлд холбогдох саналыг боловсруулж, ХНХЯ-нд хүргүүлсэн. | |
| 34 | 3.2.7. Хүнд үйлдвэрлэлийг хөгжүүлж, эрдэс түүхий эдийн боловсруулалтын түвшинг ахиулан, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэнэ: | 1. Дархан-Сэлэнгийн бүсэд хар төмөрлөгийн цогцолборыг дэд бүтцийн хамт байгуулна. | 2021 - 2024 | УУХҮЯ, "Кью эс си" ХХК, "Дархан төмөрлөгийн үйлдвэр" ХК | | Төслийн удирдлага, инженеринг, тоног төхөөрөмжийн угсралт суурилуулалт, барилгын ажлыг үргэлжлүүлнэ. 92.9% | “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ТӨХК нь 2023 оны бизнес төлөвлөгөөг “Эрдэнэс Монгол” ХХК-иар, худалдан авалтын төлөвлөгөөг Сангийн яамаар 2023 оны 4 дүгээр сард тус тус батлуулсан. Төслийн ажлын бэлтгэл хангах, судалгааны ажлын хүрээнд дараах ажлууд хийгдсэн. Үүнд:<br>-Төмөртэйн ордын гидрогеологийн судалгаа хийлгэх ажлын даалгаврыг боловсруулж батлуулсан, тендер зарлахаар ажиллаж байна.<br>-Төмрийн хүдрийн лабораторийн болон хагас үйлдвэрлэлийн туршилт хийлгэх тендерийг нийт 3 удаа зарласан боловч шаардлага хангасан компани орж ирээгүй учир дахин тендер зарлахаар ажлын даалгаврыг шинэчлэн боловсруулж, тендер зарлахаар ажиллаж байна.<br>-Төсөлд шаардлагатай нэмэлт газрыг улсын тусгай хэрэгцээнд авах Засгийн газрын тогтоол гаргуулсан.<br>- Төмөртэйн уурхайн нойтон баяжуулах үйлдвэр, хорголжийн үйлдвэрийн цахилгаан хангамжийн горимын тооцоо хийлгэх ажлын даалгавар боловсруулж батлуулан, худалдан авалтыг зохион байгуулахаар ажиллаж байна.<br>- “Монгол ган цогцолбор I” төслийн байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ (БОННҮ) хийлгэх ажлын тендерийг зарласан.<br>- Төслийн талбайн байр зүйн зургийн ажлын даалгаврыг боловсруулж батлуулан компанийн сонгон шалгаруулалтыг хийж ажлыг гүйцэтгүүлж хүлээн авсан.<br>- Төслийн талбайн газар шороонаы тэгшилгээний ажлын бэлтгэлийг хангах ажлын төлөвлөгөө боловсруулж батлуулан, талбай чөлөөлөх ажлыг эхлүүлээд байна.<br>- Төслийн боловсон хүчнийг бэлтгэж эхлэх зорилгоор хүдэр боловсруулах, хайлах, цутгах, цувихын операторын мэргэжлийн сургалт явуулах эрхийг авсан. | 30 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | - Төслийн хүрээнд хамтран ажиллах EPC гэрээт компани, хөрөнгө оруулагч компаниудтай холбоо тогтоох хүрээнд India Steel 2023 экспод оролцож төслийн танилцуулгыг хийснээр зарим мэргэжлийн компаниудтай холбоо тогтоогоод байна.<br>- “Уул уурхай, металлургийн цогцолбор” төсөл, түүний дэд төсөл болох “Монгол ган цогцолбор I” төслийн төлөвлөгөөг боловсруулж батлуулан “Эрдэнэс Монгол” ХХК-д хүргүүлсэн. | |
| 35 | | 3. Дорноговь аймагт хар төмөрлөгийн цогцолбор үйлдвэр байгуулна. | 2020 - 2023 | | | Түүхий эдийн татан авалт, тоног төхөөрөмжийн туршилт тохиргоо хийж, үйлдвэрийг ашиглалтад оруулна. 100% | “Инфинитиспейс” ХХК болон “Болд төмөр Ерөө гол” ХХК өөрийн санхүүжилтээр Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутагт “Алтанширээт үйлдвэрлэл, технологийн парк” байгуулах төслийг 2019-2025 онд хэрэгжүүлэхээр ажиллаж байна.<br>Цогцолбор 5 үйлдвэр байгуулах төсөлд нийт 420 орчим сая ам.долларын хөрөнгө оруулалт хийгдэх ба жилд 500 мянган тонн хүчин чадалтай ширэмний үйлдвэрийг дагалдах үйлдвэрүүдийн хамт байгуулахаар төлөвлөсөн.<br>Эхний шатанд газрын асуудал (140 га)-ыг бүрэн шийдвэрлэж, дэд бүтцийг бий болгох хүрээнд 12 км төмөр зам, 6,3 МВт-ын цахилгааны дэд станц, 110 кВ, 10 кВ-ын 9,4 км цахилгаан дамжуулах агаарын шугамууд барьж байгуулсан.<br>Төмрийн хүдрийг нойтон соронзон аргаар баяжуулах үйлдвэр, 1.5 сая тн/жил хүчин чадалтай Нүүрс баяжуулах үйлдвэр техник, эдийн засгийн үндэслэлийг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлж дэмжигдсэн бол паркийн хөгжлийн төлөвлөгөө, кокс-эрчим хүчний үйлдвэр”, 1.0 сая тн/жил хүчин чадалтай хорголжин төмрийн үйлдвэр, 500 мян.тн/жил хүчин чадалтай ширэмний үйлдвэрийн техник, эдийн засгийн үндэслэлийг тус тус Хүнд үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн паркийн хөгжлийн төлөвлөгөө болон нэгжийн техник, эдийн засгийн үндэслэлд дүгнэлт өгөх, зөвлөмж гаргах үүрэг бүхий зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж дэмжигдсэн. Мөн паркийн техник технологийн түвшний үнэлгээг хэлэлцэн хүлээн авч дүгнэлт гарсан.<br>Жилд 2 сая тонн хүчин чадалтай төмрийн хүдрийн нойтон баяжуулах үйлдвэрийг 2021 онд ашиглалтад оруулсан ба жилд 1 сая тонн хүчин чадалтай нүүрс | 50 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | баяжуулах үйлдвэрийн барилга угсралтын ажил, тоног төхөөрөмж суурилуулах ажил хийгдэж байна.<br>Мөн паркийн ус хангамжийг шийдэх зорилгоор “Бор хөөвөр” болон “Долоодын говь”-ийн газрын доорх усны ордоос ус дамжуулах 103 км урттай шугамын трассын зураглал хийж, “Бор хөөвөр”-дээр ус цуглуулах байгууламж байгуулах ажил, ажилчдын 5 блок байр барих болон нүүрс ачиж, буулгах талбайн газар, шороон ажлуудыг эхлүүлсэн.<br>Паркийн үйлдвэрүүдийн түүхий эд болох коксжих нүүрсийг тогтмол нийлүүлж, цаашид үйлдвэрийн найдвартай ажиллагааг хангах зорилгоор “Эрдэнэс Тавантолгой” ХК болон “Болдтөмөр Ерөө гол” ХХК-ийн хооронд харилцан ойлголцлын санамж бичгийг байгуулсан.<br>Үйлдвэрийн цутгуурын цех, дулаан боловсруулах цехийн тоног төхөөрөмж (нийт 2.8 тэрбум төгрөгийн өртөг бүхий тус бүр нь 2 тн багтаамжтай 6 ш индукцийн зуух, дулаан боловсруулалтын 1 ш зуух дагалдах хэрэгслийн хамт)-ийн захиалга /БНХАУ “Qianxi ADI Machanical Casting” Co.Ltd компанид/ хийгдсэн ба 2023 оны 6 дугаар сард татан авалт хийгдэж, угсралт суурилуулалтын ажлыг энэ онд хийж дуусгана.<br>Мөн 1.1 тэрбум төгрөгийн өртөгтэй 6 кВ-ын 1.2 км ЦДАШ-ыг барьж байгуулахаар бэлтгэл ажил /техникийн нөхцөл авсан/ хангагдсан ба 2023 оны 6 дугаар сард эхлүүлж 8 дугаар сард угсарч дуусгахаар төлөвлөсөн. | |
| 36 | | 5. "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын ҮТП байгуулах ажлын хүрээнд Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрийг барина. | 2020 - 2024 | УУХҮЯ, "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар | | Үйлдвэрийн барилгын ажил үргэлжлэх, тоног төхөөрөмжийн угсралт, суурилуулалтын ажлыг хийнэ. 80% | Зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах үйлдвэрийн ТЭЗҮ-ийг “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ нь БНХАУ China ENFI Engineering компанитай хамтран боловсруулсан бөгөөд УУХҮЯ-ны ЭБМЗ-өөр 2022.06.23-нд хэлэлцүүлэн, дэмжигдсэн.<br>Тус ТЭЗҮ-д үндэслэсэн ЗББҮ-ийн нарийвчилсан зураг төсөл боловсруулах ажлын хүрээнд БНХАУ-ын Шинжан Уйгарын ӨЗО-ны Фуюун мужид Шинжаны өнгөт төмөрлөгийн аж үйлдвэр группийн (XJNM) эзэмшлийн Зэс ба никелийн металлургийн “Xinxin Metals” компанийн үйлдвэрлэлийн бүсэд явуулахаар төлөвлөсөн Зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах металлурги-химийн үйлдвэрээс гарах хүхрийн давхар исэл агуулсан хийнээс элементийн хүхэр ялган авах туршилтын үйлдвэрийн тоног төхөөрөмжийн тээвэрлэлт болон төсөл хэрэгжүүлэх талбайн бүтээн | 70 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | байгууллалтын ажлыг оновчтой зохион байгуулж, үйлдвэрлэлийн туршилтын ажлыг 2023 оны I улиралд багтаан бүрэн дуусгахад “China ENFI Engineering Corporation”-д дэмжлэг үзүүлэх хүсэлтийг УУХҮСайдаас БНХАУ-аас Монгол Улсад суугаа элчин сайд Цай Вэнь Руй-д, Төслийн хэрэгжилт, туршилтын үйлдвэрийн тоног төхөөрөмжийн тээвэрлэлтийг эрчимжүүлэх асуудлаар “ЭҮ ТӨҮГ”-ын Ерөнхий захирлаас China ENFI Engineering компани болон Монгол Улсаас БНХАУ-д суугаа Элчин сайд Т.Бадрал нарт тус тус хүргүүлсэн.<br>Туршилтыг явуулах үйлдвэрлэлийн болон иргэний барилга байгууламжийн нарийвчилсан зураг төслийн ажлууд 100%, тоног төхөөрөмжийн захиалга, худалдан авалт 100%, тоног төхөөрөмжийн үйлдвэрлэл 90%, үйлдвэртээ урьдчилсан угсралт хийгдсэн бөгөөд туршилтын талбай дээр хүлээж авах нөхцөл хангасны дараа нийлүүлэх боломжтой, Барилга байгууламжийн суурийн ажил 2022 оны 8 дугаар сараас хийгдэж эхэлсэн, талбайн барилгын болон угсралтын ажил 50% хийгдсэн. Орон нутагт агаарын хэм 50С-ээс дээш дулаан байх нөхцөлд барилгын ажлыг эхлүүлэх боломжтой болох бөгөөд үйлдвэрлэлийн туршилтыг 2023.06.30-ны өдрийн дотор бүрэн дуусгахаар тохиролцсон байна.<br>- ЭБМЗ-өөс ЗБХБҮ-ийн ТЭЗҮ-д өгсөн зөвлөмжийн дагуу "Аж үйлдвэрийн бүсэд мөрдөх агаарын чанарын стандартууд болон зэс хайлуулах үйлдвэрийн хаягдал утааны найрлага дахь агаар бохирдуулах бодисуудын ялгарлын олон улсын стандартуудыг судалж үндэсний болгон боловсруулж батлуулах зөвлөх үйлчилгээ"-ний эхлэлийн тайланг 2023.01.26-ны өдөр “ЭҮ” ТӨҮГ-ийн Ажлын хэсэг хүлээж авсан.<br>- ШУТИС-ын УУХ-ГУУС-ын гүйцэтгэсэн "Фосфорын ордыг ашиглах урьдчилсан ТЭЗҮ боловсруулах ажил"-ын эцсийн тайланг “ЭҮ” ТӨҮГ 2022.12.21-ний өдөр хүлээн авсан.<br>- ЗБХБҮ-ийн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийх ажлын тендерт шалгарсан “Хатан далай” ХХК болон ЭҮ ТӨҮГ хооронд 2023.02.08-нд ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан. Гэрээний хугацаа 2023.07.28-нд дуусна. Эхлэлийн тайланг ирүүлсэн ба БОАЖЯ-наас ерөнхий дүгнэлт гаргуулахаар ажиллаж байна. | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | -ЗБХБҮ-ийн Техник технологийн түвшний үнэлгээ хийлгэх ажлын техникийн тодорхойлолтыг боловсруулж батлуулан тендер зарлуулахаар ХОХААБГ-т хүргүүлсэн. Тендер зарлахаар ажиллаж байна.<br>-Хүхрийн хүчлийг ашиглан фосфорын бордоо үйлдвэрлэх туршилт судалгааг Эрдэнэт үйлдвэрийн судалгаа, шинжилгээний хүрээлэнгийн ажилтнууд гүйцэтгэж байна. Мөн "Фосфорын ордыг ашиглах урьдчилсан ТЭЗҮ боловсруулах ажил"-ыг ШУТИС-ийн УУХ-ГУУС-тай гэрээ байгуулан ажиллаж, эхлэлийн тайланг ЭҮ ТӨҮГ 2022.12.21-ний өдөр хүлээн авч, дундын тайлангийн танилцуулгыг 2023.05.04-ний өдөр хийсэн.<br>Зэсийн баяжмал хайлуулах боловсруулах үйлдвэрийн ТЭЗҮ боловсруулахад 3340.4 сая, үйлдвэрийн байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний ажилд 118.77 сая ЗБХБҮ-ээс гарах хүхэрт хийнээс элементийн хүхэр ялган авах үйлдвэрлэлийн туршилтын ажилд 10174.1 сая нийт 13703.3 сая төгрөгийг "Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ"-ын хөрөнгөөр санхүүжүүлээд байна.<br>Зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах металлурги-химийн үйлдвэрийн Зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах металлурги-химийн үйлдвэрийн үндсэн болон нарийвчилсан инженерийн зураг төсөл боловсруулах, Фосфорын ордыг ашиглах ТЭЗҮ боловсруулах, үйлдвэрийн техник технологийн түвшний үнэлгээний ажилд нийт 29,111.64 сая төгрөг зарцуулахаар "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгасан байна. | |
| 37 | | 7. Үнэт металл цэвэршүүлэх үйлдвэрийг барьж байгуулна. | 2021 - 2024 | УУХҮЯ, "Эрдэнэс Алт ресурс" ХХК | | Барилгын ажлыг эхлүүлж, тоног төхөөрөмж суурилуулалт, туршилт, тохируулгыг хийнэ. 100% | Бүгд Найрамдах Казахстан Улсаас Монгол Улсад суугаа Элчин сайдын яаманд 2023.02.17-ны өдрийн 02/47 дугаар албан бичгээр БНКазУ-ын "Сымбат инженеринг" ХХК-тай цаашид баримтлах байр сууриа яамны зүгээс илэрхийлсэн. Төслийн хөрөнгө оруулалтын асуудал шийдэгдээгүй байна. | 0 |
| 38 | | 9. Оюутолгойн ордыг түшиглэн зэсийн баяжмалыг | 2021 - 2028 | УУХҮЯ | | Тоног төхөөрөмжийн захиалга, барилга | "Зэсийн баяжмал хайлуулах, цэвэршүүлэх үйлдвэрийн төсөл хэрэгжүүлэх нэгжийн талаар авах арга хэмжээний тухай" Засгийн газрын тогтоолын төсөл, холбогдох материалын хамт УУХҮСайдын 2023.01.03-ны өдрийн | 0 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | боловсруулах үйлдвэр байгуулах ажлыг эхлүүлнэ. | | | | угсралтын ажлыг эхлүүлнэ. 15% | 01/04 дүгээр албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн. Засгийн газрын 2023.01.11-ний өдрийн 18 дугаар тогтоолоор Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрийн төсөл хэрэгжүүлэх нэгжийг татан буулгах, төслийн нэгжийн чиг үүрэг, холбогдох баримт бичгийг “Эрдэнэс Монгол” ХХК-д шилжүүлэхийг УУХҮСайдад даалгасан. Уг тогтоолоор “Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр барих” төслийн нэгжийг татан буулгасантай холбоотойгоор төслийн чиг үүрэг, баримт бичгийг “Эрдэнэс Монгол” ХХК-д шилжүүлэх Ажлын хэсгийг ТНБД-ын 2023.02.01-ний өдрийн А/08 дугаар тушаалаар байгуулж, зохион байгуулсан. Төсөлтэй холбоотой бүх баримт, материалыг 2023.03.30-ны өдөр “Эрдэнэс Монгол” ХХК-д хүлээлгэн өгсөн.<br>Мөн төслийн хүрээнд Хөрөнгө оруулагчийг сонгон шалгаруулах урьдчилсан сонгон шалгаруулалтын болон Тендерийн баримт бичигт санал авахаар Сангийн яам, Эдийн засаг, хөгжлийн яаманд 2022.12.21-ний өдрийн 01/3357 албан бичгийг хүргүүлсэн ба 2023.06.05-ны байдлаар хариу албан бичиг ирүүлээгүй тул 2023.06.05-ны өдрийн 01/1366 дугаар албан бичгийг дахин хүргүүлсэн. | |
| 39 | 3.2.8. Дотоодын түүхий эдэд тулгуурласан газрын тос боловсруулах үйлдвэрийг барьж байгуулна: | 1.1. Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтыг эрчимжүүлж нөөцийг өсгөнө. | 2020 - 2024 | УУХҮЯ, АМГТГ | | Шинээр 2 талбайд БХГ байгуулсан байна. ГТ-ны олборлолт 816.2 мян.тн | Матад XX талбайн газрын тосны нөөцийг ЭБМЗ-өөр хэлэлцүүлэн батлуулж, газрын тосны баталгаат нөөц 338,78 сая тн, үүнээс ашиглалтын баталгаат нөөц 43,38 сая тн болсон. Баталгаат нөөц 1 сая тн-р нэмэгдсэн. | 50 |
| 40 | | 1.2. Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул судалгааны ажил, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, хэтийн төлөв тодорхойлно | 2020 - 2024 | УУХҮЯ, АМГТГ | | Хайгуулын ажил, хөрөнгө оруулалтын хэмжээ нэмэгдсэн байна. | Газрын тосны хайгуулын 14 талбайд нээлттэй сонгон шалгаруулалт зарлахаар бэлтгэл ажлыг хангасан.<br>Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2022 оны А/294, 2023 оны А/43, А/198 дугаар тушаалыг тус тус үндэслэн Газрын тосны хайгуулын 12 (5, 5, 2) талбайд нээлттэй сонгон шалгаруулалт зарласан. Номгон IX, Дарьганга XXIV, Хэрлэнтохой XXVIII талбайнуудад аж ахуй нэгжүүд захиалга ирүүлсэн. Номгон IX, Дарьганга XXIV талбайнуудад Газрын тосны тухай хуулийн 21 дүгээр зүйлийн дагуу ажлын хэсэг ажиллаж ялагчийг тодруулан, Бүтээгдэхүүн хуваах гэрээний төслийн хэлэлцээрийг хийж байна. Хэрлэнтохой XXVIII талбайд Газрын тосны тухай хуулийн 20 дугаар зүйлийн дагуу | 70 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | ажлын хэсэг байгуулагдан ялагчийг тодруулахаар ажиллаж байна. | |
| 41 | | 1.3. Газрын тосны хайгуулын талбайнуудад шинээр Бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулж, хайгуулын ажлын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ | 2020 - 2024 | УУХҮЯ, АМГТГ | | Шинээр 2 талбайд БХГ байгуулсан байна. | 1. Газрын тосны хайгуулын талбайнуудад шинээр Бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулж, хайгуулын ажлын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх бэлтгэл ажлыг хангаж байгаа бөгөөд гэрээлэгчгүй байгаа 10 хайгуулын талбайд хийгдсэн хайгуулын ажлын жагсаалтыг гаргуулаад байна.<br>2. Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Газрын тосны тухай хуулийн 8.1.4 дахь заалтыг үндэслэн Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2022.11.29-ний өдрийн А/294 дугаар тушаалаар хайгуулын Номгон IX, Төхөм X урд, Цагаан Элс XIII, Зүүнбаян XIV, Дарьганга XXIV талбайд нээлттэй сонгон шалгаруулалт зарласан. Тус нээлттэй сонгон шалгаруулалтад Доншен газрын тос (Монгол) ХХК газрын тосны хайгуулын Номгон IX талбайд захиалга ирүүлж, Капкорп Монголиа ХХК сонгон шалгаруулалтад оролцохоо илэрхийлээд байна.<br>Мөн Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2023.02.24-ний өдрийн А/143 дугаар тушаалаар газрын тосны хайгуулын Хонгор VIII, Баянхошуу XXII, Чойр XXV, Цайдам XXVI, Хэрлэнтохой XXVIII талбайд нээлттэй сонгон шалгаруулалт тус тус зарласан.<br>3. Газрын тосны хайгуулын Гурванбаян-XXX талбайд БХГ байгуулахаар Баян петролиум ХХК-тай хэлэлцээрээр тохиролцсон гэрээний төсөлд яамдуудаас санал авч, саналыг Бүтээгдэхүүн хуваах гэрээний төсөлд тусгасан. 2023.03.01-ний өдрийн 01/521 дугаар албан бичгээр холбогдох материалыг ЗГХЭГ-т хүргүүлсэн. | 70 |
| 42 | | 1.4. Газрын тосны хайгуулын талбайд шинээр газрын тосны орд нээж, нөөц тогтоох ажлыг зохион байгуулна | 2020 - 2024 | УУХҮЯ, АМГТГ | | Гэрээлэгчдийн хайгуул, судалгааны ажлын үр дүнтэй уялдуулан нөөц тогтоох ажлыг зохион байгуулсан байна. | Газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаанд тулгамдаж буй асуудлаар 2022.04.27-ны өдрийн Засгийн газрын хуралдаанд танилцуулга хийж 25 дугаар тэмдэглэлийг гаргуулсан. Уг тэмдэглэлд газрын тос боловсруулах үйлдвэр барихтай холбогдуулан газрын тосны хайгуул, ашиглалтын бүтээгдэхүүн хуваах гэрээт талбайг хууль тогтоомжид заасны дагуу Монгол Улсын газрын нэгдмэл санд бүртгэх, газар ашиглах гэрчилгээ олгох арга хэмжээ авч ажиллахыг БХБСайд Б.Мөнхбаатарт, газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагааг хууль тогтоомжид заасан бүрэн эрхийн | 70 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хүрээнд дэмжиж ажиллахыг бүх шатны Засаг дарга нарт даалгасан.<br>Газрын тосны ашиглалтын Матад-XX талбайн ашиглалтын 218 хав.дөр.км талбайг улсын тусгай хэрэгцээнд авах талаар Засгийн газрын тогтоолын төсөл боловсруулан холбогдох яамдаас санал авч байна.<br>Яамдаас ирүүлсэн саналыг Сангийн яам болон Хууль зүй, дотоод хэргийн яамны саналыг үндэслэн эрхлэх асуудлын хүрээнд 2023.04.14-ний өдрийн 01/948 дугаар албан бичгээр Барилга хот байгуулалтын яаманд шилжүүлсэн. | |
| 43 | | 1.5. Газрын тосны ордын ашиглалт, олборлолтыг урт хугацаанд тогтвортой хадгалж, боломжит хэмжээгээр нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулж, дэмжлэг үзүүлнэ | 2020 - 2024 | УУХҮЯ, АМГТГ | | ГТ-ны олборлолт 816.2 мян.тн | Газрын тосны экспортын үйл ажиллагааг эхлүүлэх, хилийн боомтуудыг нээлгэх талаар Улсын онцгой комисс болон Гадаад харилцааны сайд нарт 2022.04.08-ны өдөр 1/935 дугаар албан бичгийг хүргүүлсэн. Газрын тосны ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй Петрочайна Дачин Тамсаг ХХК-ийн нийгмийн даатгал, татварын асуудлаар болон газрын тосны нөөцийн талаарх танилцуулгыг УИХ-ын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хуралдаанд танилцуулан Газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээнээс Монгол Улсын хүртэх үр ашгийг нэмэгдүүлэх тухай 2022.05.24-ний өдрийн 03 дугаар тогтоол гаргуулсан. Мөн ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй Тосон-Уул-19 болон Тамсаг-21 дүгээр талбайн БХГ-г хууль тогтоомжид нийцүүлэн шинэчлэх талаар Ерөнхий сайдын 2022.05.19-ний өдрийн 78 дугаар захирамж гарч Ажлын хэсгийг Шадар сайд С.Амарсайханаар ахлуулан ажиллаж байна.<br>Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу газрын тосны ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй “Петрочайна Дачин Тамсаг” ХХК болон “Доншен газрын тос (Монгол)” ХХК-ийн газрын тосны ашиглалтын үйл ажиллагаа болон цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар 2023.05.17-ны өдөр Засгийн газрын хуралдаанд танилцуулж 21 дүгээр тэмдэглэл гаргуулсан. 2023 онд нийт 6.5 сая баррель буюу 883 мянган тонн газрын тос олборлож, экспортлох төлөвлөгөөтэйгээс 2023.01.01-2023.05.31 хүртэл нийт 2037969 баррель буюу 276710 тонн газрын тос олборлож, 1989618 баррель буюу 270546 тонн түүхий тос БНХАУ-д экспортлоод байна. | 70 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 44 | | 2.1. Газрын тос боловсруулах үйлдвэрийг түүхий эдээр хангах, дамжуулах хоолой барих санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэж, бүтээн байгуулалтын ажлыг гүйцэтгэнэ. | 2020 - 2024 | УУХҮЯ, АМГТГ | | Дамжуулах хоолойн барилга, угсралтын ажлыг үргэлжлүүлэн гүйцэтгэнэ. 90% | УУХҮЯ-ны ТНБДаргын 2021 оны А/08 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг олон улсын сонгон шалгаруулалтыг явуулж БНХАУ-ын Норинко интернейшнл компанийг шалгаруулсан. Шалгарсан компанитай гэрээ байгуулах талаар Засгийн газрын 2022.03.02-ны өдрийн 14 дүгээр тэмдэглэл, 94 дүгээр тогтоолыг тус тус гаргуулж, хоолойн байгууламж барихад шаардагдах санхүүжилтийг нүүрс урьдчилан борлуулах замаар санхүүжүүлэхээр шийдвэрлсэн. Үүний дагуу Төслийн захиалагч Монгол Улсын Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, төслийн санхүүжүүлэгч “ЭТТ” ХК, төсөл хэрэгжүүлэгч “МГТБҮ” ТӨХХК болон төслийн гүйцэтгэгч БНХАУ-ын төрийн өмчит Норинко компаниудын хооронд 2022.04.18-ны өдөр Хамтран ажиллах гэрээг, “МГТБҮ” ТӨХХК болон “Норинко” компанийн хооронд 2022.04.21-ний өдөр дамжуулах хоолойн инженерчлэл, худалдан авалт, барилга угсралтын ажил гүйцэтгэх (EPC) гэрээ, “МГТБҮ” ТӨХХК болон “ЭТТ” ХК-ийн хооронд 2022.04.22-ны өдөр дамжуулах хоолойн барилга угсралт, бүтээн байгуулалтын ажлын санхүүжилтийн гэрээг, “ЭТТ” ХК болон “Норинко” компанийн хооронд 2022.04.22-ны өдөр нүүрс худалдах, худалдан авах гэрээг тус тус байгуулсан. | 50 |
| 45 | | 2.3. Дамжуулах хоолой барих төслийн ТЭЗҮ, инженер техникийн зураг төслийг боловсруулах батлах, барилга угсралт, бүтээн байгуулалтын ажлыг зохион байгуулна | 2020 - 2024 | | | Дамжуулах хоолойн барилга, угсралтын ажлыг үргэлжлүүлэн гүйцэтгэнэ. 90% | Кемпүүдийн барилга угсралтын ажил-48%, түр замын ажил-28%, байр зүйн зураглалын судалгааны ажил-100%, мэдээлэл боловсруулах, тайлан бэлтгэх ажил-100%, геотехникийн судалгааны ажил-95%, Суурь инженерчлэлийн загвар (FEED) зураг төслийн ажил-90% байна. БОННҮ хийх ажил-100% БОАЖЯ-д хянагдаж байна. Дамжуулах хоолойн архитектур төлөвлөлтийн даалгаврын хүсэлтийг БХБЯ-нд хүргүүлсэн.<br>Төслийн ерөнхий гүйцэтгэл: Инженерчлэл-51%, Барилга угсралт-7%, Худалдан авалт-6.08%, Сэлбэг хэрэгсэл-0%. | 50 |
| 46 | | 3.1. Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутагт дотоодын түүхий эдэд | 2020 - 2024 | | | 2020-2022 онд хийж гүйцэтгэж эхэлсэн барилга-угсралтын ажлуудыг | Технологийн бус барилга байгууламжийн ажил /EPC-1/-ын барилга угсралтын ажлын гүйцэтгэл 2023.06.15-ны өдрийн байдлаар 80,3%-тай байна. Эдгээрт Түүхий ус хадгалах сав-98,69%, Оффис, сургалтын төв-81%, Хоолны газар-90%, Лаборатори-90%, Эмнэлгийн барилга-84%, Агуулах-63.7%, Нэвтрэх хаалга-1-82,80%, | 70 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | тулгуурласан газрын тос боловсруулах үйлдвэрийг барьж байгуулна. | | | | дуусгаж, лицензит байгууламжийн барилга-угсралтын ажлыг эхлүүлсэн байна. 90% | Нэвтрэх хаалга-2-56,32%, Гал унтраах ангийн барилга-68,29%, Засварын цех-57%, Үерийн ус цуглуулах талбай-82,5%, Ус зайлуулах хоолой-53,0%, Ус дамжуулах хоолой-95%, 17км авто зам-61,0%, Ус дамжуулах хоолой-/Бор хөөвөр/-72,65%, Худгийн барилга-79,74%, Цахилгаан дамжуулах агаарын шугам-96,0%-ийн тус тус гүйцэтгэлтэй. Лицензгүй технологийн байгууламжийн ажил /EPC-2/-ын Үйлдвэрийн цахилгаан станцын ажил /EPC-3/-ын ерөнхий гүйцэтгэгч БНЭУ-ын “Megha Engineering & Infrastructure Limited” (Мега инженеринг инфрастракчер лимитед) компанитай Инженерчлэл, худалдан авалт, барилгын угсралтын гэрээ байгуулах асуудлыг Засгийн газрын 2022.10.26-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэсний дагуу “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК, “Megha Engineering & Infrastructure Limited” компани хооронд 2022.10.28-ны өдөр гэрээ байгуулан 2023.05.01-ний өдөр барилга угсралтын ажлыг эхлүүлсэн. EPC 02 ажлын хүрээнд үйлдвэрийн үндсэн технологийн буюу энгийн ба вакуум нэрлэгийн байгууламж, Анхдагч процессийн (Энгийн болон Вакуум нэрлэг, Ханасан хий ялгах байгууламж) болон Дагалдах байгууламж (Агуулах сав, резервуар, Ачих буулгах байгууламж, Ус цэвэршүүлэх, ууршуулах систем, Шугам хоолойн тулгуурууд, хэрэглээний бусад байгууламжууд) баригдах бөгөөд эдгээр байгууламжуудын ажлын зургийг Испанийн Intecsa компани, EPC 03 багц ажил буюу Үйлдвэрийн 35 Мвт-ын хүчин чадалтай цахилгаан станцын ажлын зургийг MEIL компани өөрөө хийж, үйлдвэрлэхэд ихээхэн хугацаа шаарддаг генератор, уурын турбиныг ХБНГУ-ын Siemens, уурын зуухыг мөн улсын ThyssenKrupp компани үйлдвэрлэж байна. Лицензтэй технологийн байгууламжуудыг барих ажил /EPC-4/-ын лиценз эзэмшигчдийг шалгаруулж гэрээг байгуулсан.<br>Лицензтэй технологийн байгууламжийн Инженерчлэл, худалдан авалт, барилга угсралтын ажлын ерөнхий гүйцэтгэгчийг сонгох тендерийг 2023.02.27-ны өдөр хүлээн авсан, тендерт ирүүлсэн үнийг бууруулах хэлэлцээ хийхээр албан ёсоор хандсан боловч хамгийн бага боломжит үнийн санал өгсөн тул бууруулах боломжгүй гэсэн хариу аваад байна. | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 47 | | 3.2. Газрын тос боловсруулах үйлдвэрийг дэмжих тухай хуулийн төсөл боловсруулж, батлуулах ажлыг зохион байгуулна | 2020 - 2024 | | | Хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллана. | Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Эксим банк хооронд байгуулсан “Зээлийн ерөнхий хэлэлцээр”-ийн хүрээнд хэрэгжүүлж буй газрын тос боловсруулах үйлдвэрийг төлөвлөсөн хугацаанд багтаан барьж байгуулах, төслийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, төрөөс үзүүлэх дэмжлэгийг тодорхойлох, эрхзүйн зохицуулалтыг бий болгох зорилгоор “Газрын тос боловсруулах үйлдвэрийг дэмжих тухай” хуулийн төслийг УИХ-ын чуулганы 2021.01.29-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүж батлуулсан. Мөн хуулийн 3.3 дахь хэсэгт заасан Газрын тос боловсруулах үйлдвэрт төрөөс дэмжлэг үзүүлэх журмыг Засгийн газрын 2021.08.11-ний өдрийн 241 дүгээр тогтоолоор батлуулсан. | 100 |
| 48 | | 3.3. Үйлдвэрийн барилга угсралт, бүтээн байгуулалтын ажлыг төлөвлөгөөний дагуу гүйцэтгэх ажлыг зохион байгуулж, дэмжлэг үзүүлнэ | 2020 - 2024 | | | 2020-2022 онд хийж гүйцэтгэж эхэлсэн барилга-угсралтын ажлуудыг дуусгаж, лицензит байгууламжийн барилга-угсралтын ажлыг эхлүүлсэн байна. 90% | Лицензгүй технологийн байгууламжийн ажил /EPC-2/-ын ерөнхий гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах түргэвчилсэн тендерийг 2022.06.06-ны өдөр зарласан ба 2022.09.19-ний өдөр тендер хүлээж авсан. Үйлдвэрийн цахилгаан станцын ажил /EPC-3/-ын ерөнхий гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах түргэвчилсэн тендерийг 2022.05.04-ний өдөр зарласан ба 2022.07.04-ний өдөр тендер хүлээн авсан. EPC-2, EPC-3 багц ажлын тендерт хамгийн бага үнийн санал ирүүлсэн БНЭУ-ын “Megha Engineering & Infrastructure Limited” (Мега инженеринг инфраструкчер лимитед) компанитай Инженерчлэл, худалдан авалт, барилгын угсралтын гэрээ байгуулах асуудлыг Засгийн газрын 2022.10.26-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэсний дагуу “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК, “Megha Engineering & Infrastructure Limited” компани хооронд 2022.10.28-ны өдөр гэрээ байгуулсан.<br>Багц ажлын Ерөнхий гүйцэтгэгч Megha Engineering Infrastructures Limited компани зураг төслийг экспертизээр батлуулах, зохиогчийн хяналт хийх, тусгай зөвшөөрөл авч өгөх, барилгын ажлын зөвшөөрөл авахад туслалцаа үзүүлэх туслан гүйцэтгэгч компани буюу MPI болон NUBIA компаниудтай гэрээ байгуулан ажиллаж байна. Тус компани нь МГТБҮ ТӨХХК болон ТМЗ компанийн оролцоотойгоор барилгын ажил эхлүүлэх зөвшөөрөл авах, түүнд шаардлагатай бүрдэл баримт бичгийг боловсруулах, эх загвар зургийг | 50 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | батлуулах, архитектур төлөвлөлтийн даалгаврыг баталгаажуулах зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэж байна. | |
| 49 | | 3.4. Газрын тосны бүтээгдэхүүний хангамжийн тогтвортой байдлыг хангах ажлыг зохион байгуулна | 2020 - 2024 | | | Шатахууны хангамж тогтвортой байна. 2.3 сая тонн | Монгол Улсын хэмжээнд 2022 онд нийт 1.9 сая гаруй тонн газрын тосны бүтээгдэхүүн импортолсон. Үүнд 90-ээс доош октантай автобензин 33 мян.тонн, 90-ээс дээш октантай автобензин 649 мян.тонн, дизель түлш 988 мян.тонн, ТС 1 онгоцны түлш 38.4 мян.тонн, бусад бүтээгдэхүүн 201.2 мян.тонн тус тус импортолсон. 2023.06.06-ны өдрийн байдлаар улсын хэмжээнд дунджаар А-80 автобензин 21 хоног, Аи-92 автобензин 28 хоног, Аи-95 автобензин 25 хоног, дизель түлш 34 хоног, ТС-1 онгоцны түлш 45 хоног, шатдаг хий 48 хоногийн ердийн хэрэглээтэй тэнцэх үлдэгдэл, нөөцтэй байна. Газрын тосны бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлт тогтвортой байна. | 100 |
| 50 | | 3.5. Экологийн өндөр ангилал бүхий Евро-5 стандартын шатахууны хэрэглээг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулна | 2020 - 2024 | | | Евро-5 стандартын шатахууны хэрэглээ 35 хувьд хүрсэн байна. | Улсын хэмжээнд 2023 оны эхний 5 сарын байдлаар нийт 802 мянган тонн шатахуун импортлон хэрэглэснээс 103.2 мянган тонн нь Евро-5 стандартын шатахуун байна. | 70 |
| 51 | | 3.6. Баруун бүсийн шатахууны хэрэглээний тодорхой хувийг хангах зорилгоор Ховд аймагт хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар бага оврын газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэр байгуулахад дэмжлэг үзүүлнэ. | 2020 - 2024 | УУХҮЯ, АМГТГ | | Төслийн барилга, угсралтын ажлыг эхлүүлсэн байна. 50% | Ховд аймгийн Жаргалант сумын нутагт үйлдвэрийн зориулалтаар 6.0 га газар эзэмших зөвшөөрөл авсан. Мөн төслийн Байгаль орчинд нөлөөлөх байдлын Ерөнхий болон Нарийвчилсан үнэлгээний тайланг мэргэжлийн байгууллагаар хийлгэж БОАЖЯ-ны Зөвлөлөөр хэлэлцүүлсэн. Үйлдвэрийн агуулахын зураг төсөл боловсруулж, аймгийн Мэргэжлийн хяналтын газар, ОБЕГ, БХБЯ-ны Барилгын хөгжлийн төвөөр тус тус батлуулсан. Гадаад талд үүсээд буй нөхцөл байдалтай холбоотойгоор төсөл хэрэгжүүлэгч компани ТЭЗҮ-д шаардлагатай зарим тодотголыг хийж байна. | 50 |
| 52 | | 3.7. Газрын тосны төрийн өмчит | 2020 - 2024 | | | Газрын тосны судалгаа, | ЗГХЭГ-ын дарга болон Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд нарын 2021.02.26-ны өдрийн 16-А/32 дугаар | 50 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | болон төрийн өмчийн оролцоотой компани байгуулах эрх зүйн орчин бүрдүүлэх ажлыг зохион байгуулж, Газрын тосны судалгаа, шинжилгээ, хайгуул, ашиглалт, боловсруулалт, хангамжийн цогц үйл ажиллагаа явуулах төрийн өмчит Үндэсний компани байгуулна | | | | шинжилгээ,хайгуул, ашиглалт, боловсруулалт, хангамжийн цогц үйл ажиллагаа явуулах төрийн өмчит Үндэсний компани үйл ажиллагаа явуулахад бэлэн болсон байна. 50% | хамтарсан тушаалаар байгуулагдсан “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК-ийн 2019-2020 оны үйл ажиллагаанд дотоод аудит хийх ажлын хэсэг ажилласан. Үүнтэй холбогдуулан газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулж буй төрийн өмчит “Эрчис Ойл” ХХК, “Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж” ТӨҮГ, “Эрдэнэс метан” ХХК зэрэг аж ахуйн нэгжүүдийг нэгтгэн зохион байгуулж, газрын тосны хайгуул, судалгаа ашиглалт, боловсруулалт, хангамжийн үйл ажиллагаа явуулах төрийн өмчит үндэсний компани байгуулах асуудлыг ажлын хэсгийн дүгнэлт болон Засгийн газрын шийдвэрийн төсөлд тусгуулах саналыг ЗГХЭГ-т хүргүүлсэн.<br>Мөн Засгийн газрын 2021.02.17-ны өдрийн хуралдааны 11 дүгээр тэмдэглэлээр өгсөн үүрэг даалгавартай холбогдуулан Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд 2021.03-р сард Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын удирдлагатай хийсэн уулзалтын ярианы сэдэвт газрын тосны салбарт үйл ажиллагаа явуулж буй төрийн өмчит компаниудыг нэгтгэн зохион байгуулж, төрийн өмчит үндэсний компани байгуулах асуудлыг тусгуулан, хэлэлцүүлсэн. | |
| 53 | 3.5.2. Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжуулан Оросын Холбооны Улсаас Бүгд Найрамдах Хятад Ард Улс руу байгалийн хий дамжуулах хоолойн техник, эдийн засгийн үндэслэлийг дуусгаж, барилга угсралтын ажлыг эхлүүлэх бэлтгэл хангана. | 1. Монгол улсын газар нутгаар дайруулан татах хийн хоолойн судалгааг хийнэ. | 2021 - 2024 | Эрдэнэс Монгол ХХК, УУХҮЯ ЭХЯ | | Судалгааны ажил үргэлжлэн хийгдэнэ | Хийн хоолойн ТЭЗҮ боловсруулах судалгааны ажлын хүрээнд трассын дагуу байрших ашигт малтмалын илрэл, тусгай зөвшөөрлийн талаарх мэдээллийг хүргүүлсэн. Судалгааны ажил дууссан бөгөөд ТЭЗҮ-ийг тусгай зориулалтын компани “Газопровод Союз Восток” ХХК 2021.12.15-ны өдөр монголын талд хүлээлгэн өгсөн. 2022.02.28-ны өдөр Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан болон “Газпром” НХН-ийн Удирдах зөвлөлийн орлогч дарга В.А.Маркелов нар Монгол Улсын Засгийн газар болон “Газпром” НХН-ийн Хамтарсан ажлын хэсгийн 2022–2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг баталж тус төлөвлөгөөний дагуу 2022.02.28-ны өдөр инженерийн хайгуул судалгаа, зураг төслийн ажлуудын даалгаврыг баталж “Газопровод Союз Восток” ХХК болон “Газпром Проектирование” ХХН-ийн хооронд инженер хайгуул судалгаа, зураг төслийн ажлуудыг гүйцэтгэх гэрээнд гарын үсэг зурсан. Үүний дагуу 2022.04.28-ны өдөр инженерийн хайгуул судалгааны ажил эхэлж, судалгааны ажил хэвийн явагдаж байна. 2023 онд тус төслийг гүйцэтгэхэд ОХУ-аас 30 ажилтан ажиллахаар | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | төлөвлөсөн бөгөөд эдгээр хүмүүст Монгол Улсад хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгуулахаар ХНХЯ-д дэмжлэг үзүүлэх тухай 2022.10.24-ний өдрийн 03/2779 албан бичгийг хүргүүлсэн. | |
| 54 | 3.6.3. Зорилт | 2.1. Цахилгаан болон байгалийн хийн хөдөлгүүртэй тээврийн хэрэгслийн цэнэглэх сүлжээг ШТС, үйлчилгээний газруудыг түшиглэн төр хувийн хэвшлийн түншлэлээр байгуулна. | 2021 - 2024 | ЗТХЯ, УУХҮЯ ТХААГ, ХХ | | Цахилгаанаар цэнэглэх 20 цэг, хийгээр цэнэглэх 10 станц | Байгалийн хийн импорт, борлуулалтын үйл ажиллагаа эрхлэгч Юу Би Метан ХХК нь 2021 онд 1000 тонн шахсан байгалийн хий импортлон, нийслэлийн нийтийн тээврийн 100 орчим хийн хөдөлгүүртэй автобусыг цэнэглэх үйл ажиллагаа явуулсан.<br>Тус компани 2021 онд Баянзүрх дүүргийн Монелд тээврийн хэрэгслийг байгалийн хий, ШШХ, шатахуунаар цэнэглэх станц барьж байгуулахаар зураг, төслийг батлуулан, эхний хэсгийг УОК-т хүлээлгэн өгсөн. Мөн Сонгинохайрхан дүүргийн Рашаант өртөөнд байгалийн хийн агуулах, хий цэнэглэх станц барих төслийг хэрэгжүүлж, барилга байгууламжийн ажлын гүйцэтгэл 80 гаруй хувьтай явагдаж байна. | 70 |
| 55 | 3.7.13. Барилгын үйлдвэрлэлд хэрэглэгдэх цемент, арматур, хавтгай шил зэрэг үндсэн нэр төрлийн материалыг эх орны эрдэс, түүхий эдээр дотооддоо үйлдвэрлэх замаар импортыг бууруулах бодлогыг хэрэгжүүлнэ. | 1. Эрдэнэтийн гангийн үйлдвэрийн тоног төхөөрөмжийг шинэчилж, үйлдвэрлэлийн үйл ажиллагааг жигдэрүүлнэ. | 2020 - 2024 | Хувийн хэвшэл, БХБЯ, УУХҮЯ, | | Үйлдвэрлэлийн үйл ажиллагаа жигдэрсэн байна. | “Бэрэн групп” ХХК болон түүний хамаарал бүхий компаниудын Хөгжлийн банкнаас авсан зээл, өрийн асуудлыг шийдэгдэх хүртэл төслийн ажил зогсонги байдалд байна. | 0 |
| 56 | | 2. Барилгын хавтгай шилний үйлдвэр байгуулж ашиглалтад оруулна. | 2020 - 2024 | Хувийн хэвшэл, БХБЯ, УУХҮЯ, НЗДТГ | | Шилний үйлдвэрийн барилгын ажлыг үргэлжлүүлнэ. | “Эрдэс плазм” ХХК нь шилний үйлдвэрээ Багахангай дүүрэгт байгуулахаар төлөвлөж байгаа ба үйлдвэрийн үндсэн түүхий эдийн судалгааг хийж гүйцэтгэн Дорноговь аймгийн Сайхандулаан сумын нутагт байрлах Баян-Уул судлын цахиурын ордын нөөцийн шинэчилсэн тооцооны ажлын үр дүнгийн тайланг УУХҮЯ-ны ЭБМЗ-ийн 2023.04.22-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлсэн. | 30 |
| 57 | | 3. Баруун бүсэд Ховд-Эко цементийн үйлдвэрийг ашиглалтад оруулна. | 2020 - 2024 | Хувийн хэвшэл, БХБЯ, УУХҮЯ, Ховд аймгийн ЗДТГ | | Цементийн үйлдвэрийн зүгшрүүлэлт тохируулгын ажлыг гүйцэтгэнэ. | “Вестерн холд” ХХК-ийн хэрэгжүүлж байгаа жилд 300 мян.тн цемент үйлдвэрлэж, баруун бүсийн цементийн хэрэглээг бүрэн хангах хүчин чадалтай “Ховд эко цемент”-ийн үйлдвэр 2022.10.28-ны өдөр ашиглалтад орсон ба үйлдвэрийн Чулуунцар бутлах хэсгийг 2023.04.21-ний өдөр ашиглалтад оруулсан | 100 |
| 58 | | 4. Барилгын материалын | 2021 - 2024 | УУХҮЯ | | Барилгын материалын | Эрх зүйн тусгайлсан хэрэгцээ шаардлага бий эсэхийг тодруулах зорилгоор Түгээмэл тархацтай ашигт | 50 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | түүхий эдийн орд, илэрцийн хайгуулыг эрчимжүүлж бүс нутгуудад үйлдвэр байгуулах түвшинд нөөц тогтоох хууль эрхзүйн орчныг бүрдүүлнэ. | | Хамтрагч нь БХБЯ | | түүхий эдийн орд, илэрцийн хайгуулыг эрчимжүүлж, бетоны дүүргэгч материал /элс, хайрга, дайрга/-ын хүртээмжийг нэмэгдүүлнэ. | малтмалын тухай хуулийн бусад холбогдох хуулиудтай зөрчил, давхардал, хийдэл байгаа эсэхийг тогтоож, тодруулах судалгааг Хууль зүй, дотоод хэргийн яамтай хамтран зохион байгуулсан. Энэхүү судалгааны үр дүнд Түгээмэл тархацтай ашигт малтмалтай холбоотой харилцааг зохицуулах тусгайлсан хууль шаардлагагүй гэж тогтоосон бөгөөд Ашигт малтмалын тухай хуультай нийцүүлэхээр ажиллаж байна.<br>Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2023.03.06-ны өдрийн А/55 дугаар тушаалаар Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг шинэчлэн боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг шинэчлэн байгуулсан.<br>Ажлын хэсгийн зүгээс Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу хуулийн хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэх аргачлал, хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээ, хуулийн төслийн зардлын тооцоо зэрэг тайланг эцэслэн боловсруулсан.<br>Дээрх ирүүлсэн саналуудыг нэгтгэж, Хууль тогтоомжийн тухай хуулийн 15.5-д заасны дагуу Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалыг 2023 оны 5 дугаар сарын 02-ны өдөр Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Сангийн сайд Б.Жавхлан, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар нараар батлуулсан.<br>Улмаар 2023.05.09-24-ний хооронд уг хуулийн төсөлд дахин 15 хоногийн хугацаанд санал авч, 5 дугаар сарын 23, 24-ний өдрүүдэд Геологи, уул уурхайн салбарын албан хаагчид, Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй гадны хөрөнгө оруулагч байгууллагуудын дунд нийтдээ 150 хүнийг хамарсан хэлэлцүүлгийг зохион байгуулаад байна. Одоогийн байдлаар хуулийн төслийг ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэхээр бэлтгэж ажлыг хангаж байна.<br>Хуулийн төсөлд нийтдээ 45 хоног, 9 удаагийн хэлэлцүүлгээр давхардсан тоогоор 165 иргэн, аж ахуй нэгж, төрийн бус байгууллага болон төрийн байгууллагаас 1450 орчим санал ирүүлээд байна. | |
| ДӨРӨВ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО | | | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 59 | 4.2.5. Төрийн албан хаагчийн үйл ажиллагааг үнэлэхдээ ажлын гүйцэтгэл, үйлчлүүлэгчийн үнэлгээ, ёс зүй, сахилга хариуцлагыг шалгуур болгож, ёс зүйн зөрчил гаргасан төрийн алба хаагчид хүлээлгэх хариуцлагыг чангатгана. | 3. Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэмд өөрчлөлт оруулна. Төрийн албаны үнэт зүйл, зарчим, манлайллыг өдөр тутмын үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх талаар сургалт, сурталчилгааны хөтөлбөрийг батлуулж, хэрэгжилтийг хангаж ажиллана. | 2021 - 2024 | Яамд, ТАЗ, УАкадеми | | Сургалт, сурталчилгааг явуулснаар үнэт зүйл, үндсэн зарчмаа хэрэгжүүлж, манлайллыг хангаснаар ёс зүйн зөрчил буурна. | УУХҮЯ нь төрийн албаны үнэт зүйл, зарчим, манлайллыг өдөр тутмын үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх талаар сургалтын хөтөлбөрийг баталж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. | 100 |
| 60 | 4.5.5. Америкийн Нэгдсэн Улс, Япон, Европын Холбоо, Энэтхэг, Бүгд Найрамдах Солонгос Улс, Турк зэрэг өрнө, дорнын улс, холбоотой "гуравдагч хөрш"-ийн бодлогын хүрээнд түншлэлийн харилцааг өргөжүүлэн, эдийн засгийн хамтын ажиллагааг бэхжүүлж, бусад улстай харилцан | 4. БНЭУ-тай Стратегийн түншлэлийг улам бэхжүүлж, БНЭУ-ын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлээр хэрэгжиж буй Газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах төслийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. | 2021 - 2024 | УУХҮЯ, СЯ Хамтрагч ГХЯ | | Газрын тосны үйлдвэрийн төслийн ажил урагшилна. | Технологийн бус барилга байгууламжийн ажил /EPC-1/-ын барилга угсралтын ажлын гүйцэтгэл 2023.03.30-ны өдрийн байдлаар 80,3%-тай байна. Эдгээрт түүхий ус хадгалах сав-98,69%, оффис, сургалтын төв-81%, хоолны газар-90%, лаборатори-90%, эмнэлгийн барилга-84%, агуулах-68,0%, нэвтрэх хаалга-1-83,0%, нэвтрэх хаалга-2-56,3%, гал унтраах ангийн барилга-68,3%, засварын цех-57%, үерийн ус цуглуулах талбай-82,5%, ус зайлуулах хоолой-53,0%, ус дамжуулах хоолой-95%, 17км авто зам-61,0%, ус дамжуулах хоолой-/Бор хөөвөр/-72,65%, худгийн барилга-79,74%, цахилгаан дамжуулах агаарын шугам-96,0%-ийн тус тус гүйцэтгэлтэй. Лицензтэй технологийн байгууламжуудыг барих ажил /EPC-4/-ын лиценз эзэмшигчдийг шалгаруулсан, Устөрөгчийн байгууламжийн лиценз эзэмшигч Итали Улсын Кинетикс текноложи компанитай, Хүхэр ялгах байгууламжийн лиценз эзэмшигч Франц Улсын Аксенс компани, Бензин боловсруулах, Гидрокрекинг, Дизелийн гидроцэвэрлэгээ, Дизелийн гидроцэвэрлэгээ, Шингэрүүлсэн шатдаг хий ялгах байгууламжуудын лиценз эзэмшигч АНУ-ын ЮүӨүПи Хонивэлл компанитай тус тус гэрээг байгуулсан. Лицензтэй технологийн байгууламжийн Инженерчлэл, худалдан | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлэх чиглэлээр идэвхтэй ажиллана. | | | | | | авалт, барилга угсралтын ажлын ерөнхий гүйцэтгэгчийг сонгох тендерийг 2023.02.27-ны өдөр хүлээн аваад байна. Лицензгүй технологийн байгууламжийн ажил /EPC-2/-ын ерөнхий гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах түргэвчилсэн тендерийг 2022.06.06-ны өдөр зарласан ба 2022.09.19-ний өдөр тендер хүлээж авсан. Үйлдвэрийн цахилгаан станцын ажил /EPC-3/-ын ерөнхий гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах түргэвчилсэн тендерийг 2022.05.04-ний өдөр зарласан ба 2022.07.04-ний өдөр тендер хүлээн авсан. EPC-2, EPC-3 багц ажлын тендерт хамгийн бага үнийн санал ирүүлсэн БНЭУ-ын “Megha Engineering & Infrastructure Limited” (Мега инженеринг инфраструктчер лимитед) компанитай Инженерчлэл, худалдан авалт, барилгын угсралтын гэрээ байгуулах асуудлыг Засгийн газрын 2022.10.26-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэсний дагуу “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК, “Megha Engineering & Infrastructure Limited” компани хооронд 2022.10.28-ны өдөр гэрээ байгуулсан. Багц ажлын Ерөнхий гүйцэтгэгч Megha Engineering Infrastructures Limited компани зураг төслийг экспертизээр батлуулах, зохиогчийн хяналт хийх, тусгай зөвшөөрөл авч өгөх, барилгын ажлын зөвшөөрөл авахад туслалцаа үзүүлэх туслан гүйцэтгэгч компани буюу MPI болон NUBIA компаниудтай гэрээ байгуулан ажиллаж байна. Тус компани нь МГТБҮ ТӨХХК болон ТМЗ компанийн оролцоотойгоор барилгын ажил эхлүүлэх зөвшөөрөл авах, түүнд шаардлагатай бүрдэл баримт бичгийг боловсруулах, эх загвар зургийг батлуулах, архитектур төлөвлөлтийн даалгаврыг баталгаажуулах зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэж байна. | |
| ТАВ. НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО | | | | | | | | |
| 61 | 5.1.8. Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрч, олон жил орхигдсон 8 мянган га талбайг нөхөн сэргээнэ. | 1. Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрсэн газрыг нөхөн сэргээнэ. | 2020 - 2024 | УУХҮЯ, АНЗДТГ, БОАЖЯ МХЕГ | 84,0 сая төгрөгөөр Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт | Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрсэн 2000 га талбайд нөхөн сэргээлт хийсэн байна. | 2023 оны уул уурхайн компаниудын ашиглалтын үйл ажиллагааны баталгаажсан төлөвлөгөөнд техникийн нөхөн сэргээлтийг 1322.6 га талбайд, биологийн нөхөн сэргээлтийг 1227 га талбайд, дүйцүүлэх хамгаалах ажлыг 104337.6 га талбайд нөхөн сэргээлт хийхээр, “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд 2023 онд 1362.1 га талбайд 6.3 сая мод тарихаар төлөвлөсөн байна. Ашигт малтмалын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.6.3 дахь заалтын дагуу 2022 оны ашиглалтын үйл ажиллагааны гүйцэтгэлийн тайланг | 90 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 2023 оны 2 дугаар сард ирүүлдэг. Одоогийн байдлаар ашиглалтын үйл ажиллагааны баталгаажсан 33 тайлангаар техникийн нөхөн сэргээлтийг 156.4 га талбайд, биологийн нөхөн сэргээлтийг 148.4 га талбайд, дүйцүүлэх хамгаалах ажлыг 145.8 га талбайд хийсэн байна. Мөн “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд 466 га талбайд 452,617 ширхэг мод тарьсан байна. | |
| 62 | 5.1.12. Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох, бүтээмжтэй, хүртээмжтэй ногоон хөгжлийн бодлого хэрэгжүүлж, хүлэмжийн хийн ялгарлыг 12.3 хувиар бууруулна. | 2. Уур амьсгалын өөрчлөлтийн Парисын хэлэлцээрт оруулах үндэсний тодорхойлсон хувь нэмрийн хэрэгжилтийг хангана. | 2020 - 2024 | БОАЖЯ, ЭХЯ, БХБЯ, ЗТХЯ, СЯ, ХХААХҮЯ, УУХҮЯ ОБЕГ, АНЗДТГ, ҮХГ | | Эрчим хүч, хөдөө аж ахуй, барилга, тээвэр, аж үйлдвэр, хог хаягдлын салбарын хүлэмжийн хийн ялгарлыг бууруулж, нүүрстөрөгчийн шингээлтийг нэмэгдүүлэх төсөл хэрэгжүүлсэн байна. | Засгийн газрын 2019 оны 407 дугаар тогтоолоор батлагдсан “Парисын хэлэлцээрийг хэрэгжүүлэх Үндэсний тодорхойлсон хувь нэмэр” бодлогын баримт бичигт манай байгууллагаас хариуцан хэрэгжүүлэх зорилт арга хэмжээний хэрэгжилтийг 2022 оны байдлаар гарган БОАЖЯ-нд хүргүүлсэн.<br>Манай улс газрын тосны бүтээгдэхүүний хэрэглээгээ 100 хувь импортоор хангаж байгаа бөгөөд 2022 онд улсын хэмжээнд 1,9 сая тонн газрын тосны бүтээгдэхүүн импортлон хэрэглэснээс 1,7 сая тонн нь бүх төрлийн шатахуун байна. Үүнээс 384 мянган тонн нь Евро-5 стандартын шатахуун байгаа бөгөөд дотоодын хэрэглээний нийт шатахууны 23 хувийг эзэлж байгаа нь өнгөрсөн онтой харьцуулахад 36 хувиар өссөн үзүүлэлт юм. Цаашид зорилт арга хэмжээний хүрээнд тус шатахууны хэрэглээг нэмэгдүүлэх хүрээнд Агаарын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.6-д “Монгол Улсын стандартаар тогтоосон экологийн хамгийн өндөр ангиллаас доош ангиллын, эсхүл уг ангиллын стандартын шаардлага хангаагүй автобензин, дизель түлшийг жижиглэнгээр худалдан борлуулах”-ыг хориглохоор тусгуулсан.<br>Евро-5 стандартын шатахуун нь энгийн ангиллын шатахуунаас үнэтэй байдаг бөгөөд тухайлбал, 2023 оны 03 дугаар сарын хил үнэ Аи-92 автобензиний хувьд К-2 ангилал 705 ам.доллар/тонн, К-5 ангилал 903 ам.доллар/тонн байгаа нь 198 ам.доллар/тонны зөрүүтэй байна. Үүнээс үүдэн тус бүтээгдэхүүний импортын хэмжээ бага байгаа хэдий ч дээрх хууль, протокол, гэрээний эрхзүйн бичиг баримтын хүрээнд жил бүр нэмэгдүүлэх арга хэмжээг шат дараатай хэрэгжүүлэн ажиллаж байна.<br>2023.03.28-ны өдрийн байдлаар 90 дээш октантай автобензин энэ оны эхний 3 сарын байдлаар 150 орчим тонн импортлоод байна. | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Зорилт 6. Нүүрсний уурхайн метан хийг ашиглах<br>Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ашигт малмал, газрын тосны газар Монгол улсын Засгийн газрын шийдвэрээр 2018 оноос хойш уламжлалт бус газрын тосны /Нүүрсний давхаргын метан хий/ зургаан Бүтээгдэхүүн хуваах гэрээ (БХГ) байгуулсан.Үүнд:<br>Нүүрсний давхаргын метан хийн Бүтээгдэхүүн хуваах гэрээ (БХГ)-т зургаан талбайд микросейсмийн 2 хэмжээст чичирхийллийн судалгаа нийт 1293 тууш.км, хайгуулын нийт 65 цооног (нийт 38754 4,) өрөмдсөн. Өнөөдрийн байдлаар нүүрсний давхаргын метан хийн хайгуулын зургаан талбайд 2023 онд нийт 21,18 сая ам.долларын төлөвлөгөө, төсөвт өртөг бүхий геологи, хайгуулын ажлыг хийхээр батлуулаад байна. | |
| ҮНЭЛГЭЭНИЙ ДҮН | | | | | | | | **66.6** |

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ